

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАГШИЙН УР ЧАДВАРААС ШАЛТГААЛЖ БҮЛГИЙН ТОО, АНГИ ДҮҮРГЭЛТ  
ХАРИЛЦАН АДИЛГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ  
БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2020/03/-ГА



Дархан-Уул аймаг

2020 он

Энэхүү аудитын тайлангай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат  
Утас: 70373089 Цахим хаяг: chultembatch@audit.gov.mn  
Аудитын менежер Ш.Мөнхбаяр  
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  
Ахлах аудитор С.Батцэцэг  
Утас: 70378845 Цахим хаяг: batselsegs@audit.gov.mn  
Аудитор У.Батсүрэн  
Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn  
Аудитор С.Санжаажав  
Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn  
Аудитор Ч.Гантулга  
Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn  
Аудитор Б.Алтанзул  
Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn  
Аудитор Н.Отгонцэцэг  
Утас: 70378845 Цахим хаяг: aotgontsetseg@audit.gov.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг .....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....	6
1.1. Мөрдөгдөж буй хууль, эрх зүйн уялдааг сайжруулах шаардлагатай байна. ....	7
1.1.1. Боловсролын тухай хуулийн зарим заалт бусад хуулийн заалттай нийцээгүй, хуульд заасан дүрэм, журам, норм норматив бүрэн батлагдаагүй байна. ....	7
1.1.2. Салбарын яамнаас баталсан сургалтын бодлого хөтөлбөр, төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго, зорилттой уялдсан байна. ....	11
1.2. Төрийн өмчийн сургуулийн хүчин чадал 26 хувиар хэтэрсэн байна.....	12
1.2.1 Хамран сургалтын хувь нэмээгдэж, төрийн өмчит сургуульд нэг ангид ногдох хүүхдийн тоо хэтэрсэн байна. ....	12
1.2.2 Барилгын ашиглалтын хугацаа дууссан ЕБС-ийн барилгуудад их завсар хийгдээгүй байна. ....	14
1.2.3 Зарим мэргэжлийн багшийн хүрэлцээ дутагдалтай байна. ....	17
1.3 Сургуулиудын үйл ажиллагааны санхүүжилтийг бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна.....	20
1.3.1. Төсвийг бодитой төлөвлөж, төлөвлөсөн дүнгээр хуваарилсан байна. ....	20
1.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна. ....	23
<b>БҮЛЭГ 2.    ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ БИЕЛҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.</b> .....	<b>29</b>
2.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан боловсрол эзэмшүүлж, сургалтын чанарт жил бүр үнэлгээ хийж байна.....	29
2.1.1 Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг явуулжээ. ....	29
2.1.2. Аймгийн БСУГ-аас сургуулиудын сургалтын чанарт хөндлөнгийн үнэлгээ жил бүр хийж байна. ....	31
2.2. Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын үр нөлөө харилцан адилгүй байна. ....	36
2.2.1 Аймгийн БСУГ-ын ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд хяналт үр нөлөөгүй байна. ....	36
2.2.2 Ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт харилцан адилгүй байна. ....	38
Саналд өгсөн тайлбар: .....	41
ДҮГНЭЛТ:.....	42
ЗӨВЛӨМЖ:.....	43
ХАВСРАЛТУУД:.....	44

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ОУ	Олон улс
УИХ	Улсын Их Хурал
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ОХУ	Оросын Холбооны Улс
БТХ	Боловсролын тухай хууль
БДБТХ	Бага, дунд боловсролын тухай хууль
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ЕБ	Ерөнхий боловсрол
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ААН	Аж ахуйн нэгж

## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дархан-Уул аймгийн ЕБС-д сурч буй хүүхдийн тоог хүчин чадалд харьцуулсан үзүүлэлт	12
Хүснэгт 2	Барилгын насжилт өндөртэй сургуулийн барилга	14
Хүснэгт 3	ЕБС-д ажиллаж буй багшийн тоо	18
Хүснэгт 4	Төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа	20
Хүснэгт 5	Дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ	22
Хүснэгт 6	Хувьсах зардлын судалгаа	23
Хүснэгт 7	Сурах бичгийн дутагдал	24
Хүснэгт 8	Багшийн мэргэжил дээшлүүлэх зардлын гүйцэтгэл	25
Хүснэгт 9	БСШУЯ-наас олгосон санхүүжилт	27
Хүснэгт 10	Хичээл, судлагдахууныг стандарт цагаар гүйцэд ороогүй сургуулиудыг нэгтгэн үзүүлсэн хүснэгт	29
Хүснэгт 11	БҮТ-ийн түүвэрт хамрагдан судалгаанд оролцсон сургуулиудын жагсаалт	31
Хүснэгт 12	Аймгийн хэмжээнд шалгагдсан 5 дугаар ангиудын шалгалтын дүнг сургуулиудаар жагсаасан хүснэгт	32
Хүснэгт 13	Аймгийн хэмжээнд шалгагдсан 9 дүгээр ангиудын шалгалтын дүнг сургуулиудаар жагсаасан хүснэгт	32
Хүснэгт 14	Түүвэрт хамрагдан шалгагдсан 5 дугаар ангиудын шалгалтын дүнг улсын дундажтай харьцуулсан хүснэгт	32
Хүснэгт 15	Түүвэрт хамрагдан шалгагдсан 9 дүгээр ангиудын шалгалтын дүнг улсын дундажтай харьцуулсан хүснэгт	32
Хүснэгт 16	Түүвэрт хамрагдан шалгагдсан 12 дугаар ангиудын шалгалтын дүнг судлагдахуун бүрээр нь харьцуулсан хүснэгт	33
Хүснэгт 17	Аймгийн дунджийг улсын дундажтай харьцуулан нэгтгэсэн хүснэгт	33
Хүснэгт 18	Түүвэрт хамрагдсан сургуулиудын шалгалтын дүнг судлагдахуун бүрээр харуулсан хүснэгт	34
Хүснэгт 19	Сургууль бүрийн авсан элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дунджийг харуулсан хүснэгт	35
Хүснэгт 20	Багш мэргэжлээр төгссөн оюутны тоо	38
Хүснэгт 21	МХГ-ын хяналт шалгалтын хамарсан хүрээ	39

## Зургийн товьёг


№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		

## Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ЕБС-ийн хүчин чадал /мянган хүүхдээр/	12
Дүрслэл 2	ЕБС-иуд 2016-2019 онд нийлүүлсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн /сая.төг/	17
Дүрслэл 3	Шаардлагатай багшийн тоо	18
Дүрслэл 4	Дотуур байранд хамрагдсан хүүхдийн тоо	22
Дүрслэл 5	Хандиваар авсан хөрөнгө /сая.төг	28

## Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Боловсролын тухай хуулийн дагуу батлагдаагүй дүрэм, журам, норм норматив	45
Хавсралт 2	Боловсролын тухай хууль, түүнд оруулж баталсан бусад хуулиудын харилцан уялдаа	47
Хавсралт 3	Дархан-Уул аймагт 2016-2019 онд төрийн өмчийн сургуулийн барилгад хийгдсэн засварын судалгаа	48
Хавсралт 4	ЕБС-иудад ирсэн хөрөнгийн нэгдсэн дүн	49
Хавсралт 5	Төрийн өмчийн сургуулийн нэг суралцагчид ногдох зардал	50
Хавсралт 6	Төрийн өмчийн бус сургуулийн нэг суралцагчид ногдох зардал	51



<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.</p>
<b>Аудитын зорилт</b>	<p>“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➢ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх;</li><li>➢ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;</li></ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	<p>Аудитыг Дархан-Уул аймгийн ИТХ, Боловсрол, соёл, урлагийн газар, ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Статистикийн хэлтэс, төрийн болон хувийн өмчийн ЕБС-уудын 2016-2019 оны үйл ажиллагааг /2016-2017, 2107-2018, 2018-2019 буюу сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэв.</p>
<b>Аудитын хязгаарлалт</b>	.....
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, нотлох зүйлсийг цуглуулан нягтлан шалгах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг ажлыг гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.</p>
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>	<p>Аудитыг Дархан-Уул аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер Ш.Мөнхбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батцэцэг, аудитор У.Батсүрэн, Б.Алтанзул, Ч.Гантулга, С.Санжаажав, Н.Отгонцэцэг нар хамтран төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын дэд төлөвлөгөөг 2020 оны 08 дугаар сарын 27-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 12 хүртэл гүйцэтгэж, тайланг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор нэгтгэн Гүйцэтгэлийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн дотор тэргүүлэх аудитораар баталгаажуулж хүргүүлэв.</p>
<b>Хүндрэл бэрхшээл</b>	.....

## **БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙНА.**

1.1. Мөрдөгдөж буй хууль, эрх зүйн уялдааг сайжруулах шаардлагатай байна.

1.1.1. Боловсролын тухай хуулийн зарим заалт бусад хуулийн заалттай нийцээгүй, хуульд заасан дүрэм, журам, норм норматив бүрэн батлагдаагүй байна.

1.1.1.1. Салбарын яамнаас зарим дүрэм, журам, норм нормативыг батлаагүй байна.

Боловсролын тухай хуулиар бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 7, салбарын сайд болон бусад сайдын хамтарсан тушаалаар 24, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 9, нийт 40 заалтад холбогдох дүрэм, журам, норм нормативыг батлахаар заасан боловч хуулийн дараах заалтууд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Хуулийн 16 дугаар зүйлийн 16.7<sup>1</sup>-д боловсролын асуудалд эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг дангаараа, орон тоог Сангийн яамтай хамтран батлахаар заасан байтал дүрмийг Засгийн газар, бүтэц орон тоог БСШУСС баталжээ. Дээрх заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд салбарын яам багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, Сангийн яамтай хамтран орон тоог батлах заалтыг хэрэгжүүлээгүй;
- Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуулийн 25 дугаар зүйлийн 25.6<sup>2</sup>-д заасан боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг батлаагүй;
- Салбарын яам хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.23<sup>3</sup>-т дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах эрхээ хэрэгжүүлээгүй;
- Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.24<sup>4</sup>-т заасны дагуу БШУС-ын 2013 оны А/287 дугаар тушаалаар багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмыг баталсан хэдий ч БСШУЯ-ны 2017 оны 2/789 тоот албан бичгээр хасалт хийж, шинэчлэн боловсруулаагүй;
- Салбарын сайд, Сангийн сайдтай хамтран хуулийн 39 дүгээр зүйлийн 39.12<sup>5</sup>-т зааснаар төрийн өмчийн ЕБС-ийн өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг батлаагүй;
- Засгийн газраас хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3<sup>6</sup>-т заасан нэг сурагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг

<sup>1</sup> Багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон тоог санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална;

<sup>2</sup> Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;

<sup>3</sup> Төрийн өмчийн цэцэрлэг, ЕБС, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах;

<sup>4</sup> Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам батлах;

<sup>5</sup> Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална;

<sup>6</sup> Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно;

БСШУС, Сангийн сайдын 2007 оны 306/237 дугаар хамтарсан тушаалаар баталсан хэдий ч жил бүр шинэчлэн тогтоогоогүй;

- Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3<sup>7</sup>-т төрийн бус өмчийн ЕБС-ийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолоор баталснаас хойш шинэчлэн тогтоогоогүй;
- Засгийн газар хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4<sup>8</sup>-т заасан гадаад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлж байгаа байгууллагад дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг батлаагүй байна. /Хавсралт №1-ээс үзнэ үү/

Мөн Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг батална гэсэн хэдий ч журам батлагдаагүй байна.

1.1.1.2. Салбарын яам захиргааны хэм хэмжээний актад холбогдох талуудын саналыг тусгасан уу? /эрх ашиг нь хөндөгдөх, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайлан, зөвлөмж, мэргэжлийн судлаач эрдэмтэд зэрэг/

Орон нутагт хамааралгүй.

1.1.1.3. Боловсролын салбарт мөрдөж буй зарим эрх зүйн баримт бичиг өнөөгийн хэрэгцээ шаардлага, хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлж, шинэчлэн боловсруулаагүй байна.

Боловсролын тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хуулиудын зарим зүйл, заалтыг оруулж баталжээ. Эдгээр хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотойгоор Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль шинэчлэн баталсантай холбогдуулан хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 43 дугаар зүйлийн 43.1.8 дахь заалтуудыг өөрчлөөгүй;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтэй холбоотойгоор хуулийн 20 дугаар зүйлийн 21.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй;
- Төрийн албаны тухай хууль шинэчлэн баталсан холбоотой хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, 43.6, 43.7 дугаар заалтыг шинэчлэн батлаагүй байна. /Хавсралт №2-оос үзнэ үү/

Мөн Боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиуд түүнд нийцүүлэн гарсан зарим дүрэм, журмын заалтууд, мөн бусад хууль эрх зүйн актуудтай уялдаагүй, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна. Үүнд:

<sup>7</sup> Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг тухайн боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөртэй нь уялдуулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

<sup>8</sup> Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна



- Төрийн өмчийн ЕБС-ийн хувьд Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д эцэг, эх, асран хамгаалагч *“хүүхдээ аль сургуульд ямар хэлбэрээр суралцуулахыг зохих журмын дагуу сонгох”* эрхтэй гэж заасан боловч хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1</sup>.6-д аймаг, нийслэлийн боловсролын газар *“орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамрах сургах тойрог тогтоох”* эрхтэй байхаар заасантай уялдаагүй;
- БСШУС, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайд нарын 2007 оны 307/91/237<sup>9</sup> дугаар хамтарсан тушаалаар баталсан журамд анги дүүргэлтийг бага ангид 30-35, дунд, ахлах ангид 32-35 хүүхэдтэй байхаар баталсан нь Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305<sup>10</sup> дугаар тушаалаар баталсан дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3.6<sup>11</sup>-д заасан анги дүүргэлтийн хүүхдийн тоотой уялдаагүй;
- Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.9-д сургуулийн зөвлөл хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх гэж заасан нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т ЕБС-д 6 настай хүүхдийг элсүүлнэ гэсэн заалттай уялдаагүй;
- Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.22 дахь *“... албан тушаал өөрчлөгдөх тохиолдолд цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаал эрхэлж байгаа багшийн мэргэжлийн зэрэг хэвээр хадгалагдах”* гэсэн заалт, БСШУСС-ын 2018 оны А/812 дугаар тушаалаар баталсан *“Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”* нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан *“Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”*-д заасантай хэрхэн уялдах нь тодорхойгүй;
- БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив нь 1 км-ээс хэтрэхгүй зайд байрладаг цогцолбор сургуулийн хувьд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй. Мөн дээрх тушаалаар баталсан хичээл зохицуулагчийн албан тушаалын ангилал зэрэглэлийг эрх зүйн баримт бичигт тусгаагүй;
- Эрүүл мэндийн сайд, БСШУСС-ын 2018 оны А/494, А/761 дүгээр хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт сэтгэл зүйчийг орон тоогоор ажиллуулах үүрэг өгч, ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн зааврыг баталсан боловч Боловсролын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолд албан тушаалын ангилал зэрэглэлийг батлаагүй;
- Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т *“Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна”* гэж заасан боловч үр

<sup>9</sup> Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтын цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай

<sup>10</sup> Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм

<sup>11</sup> Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 30 хүүхдээс ихгүй, өдөр өнжүүлэх бүлэг болон 6 настай 1-р ангид хамрагдах хүүхдийн тоог тухайн хот, суурины хүн амын тоо, нягтрал, бүтэц бүрэлдэхүүнийг үндэслэн зургийн даалгаврын дагуу тогтооно. 6 настай хүүхдийн онцлогоос хамаарч анги дүүргэлтийг 20-24 сурагчтай байхаар тооцох нь зохимжтой.

дүнгийн урамшуулал, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн албан тушаалтуудад олгохоор хуульчилсан нь харилцан уялдаагүй;

- Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар насан туршийн боловсролын байгууллагын талаар нэмсэн боловч ажилтнуудын албан тушаалын зэрэглэл, хуулийн 43 дугаар зүйлд заасан нийгмийн баталгааг тодорхой заагаагүй;
- БСШУЯ-ны 2017 оны 2/789 тоот албан бичгээр сайдын 2013 оны А/287 дугаар тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг улсын нэгдсэн бүртгэлээс хассан бөгөөд одоогоор шинэчлээгүй;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд ЕБС-ийн багш, туслах багш, албан хаагчдын ажлыг үнэлж, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно гэж заасан хэдий ч ажлын үр дүнг хэрхэн үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй;
- Боловсролын тухай хууль, Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолоор баталсан “Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм”-д багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага гэж ямар байгууллага болох талаар тодорхой заагаагүй;
- Хуулийн 28<sup>1</sup>.1.3-т “багш, сурагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” гэсэн заалт нь аймаг, нийслэлийн боловсролын газрын төсвийн хувьд хүндрэлтэй, Төсвийн тухай хуультай уялдаагүй;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна” гэж заасан боловч Төсвийн тухай хууль, бусад эрх зүйн баримт бичигт тодорхой заагаагүйгээс хуулийн заалт хэрэгжих боломжгүй;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3<sup>12</sup>-т аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ багшийн ёс зүйн хороотой байхаар заасан нь БСШУСС-ын 2018 оны А/243 дугаар тушаалтаар баталсан дүрэм, журамтай уялдаагүй;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна” гэж заасан боловч зарцуулах төсөв хөрөнгө, түүнд ажиллах орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг тодорхой заагаагүй байна.

1.1.1.4. Тусгай хэрэгцээт, Хилийн чанад дахь ОУ-ын хөтөлбөртэй сургуулийн чанарын үнэлгээг хийх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8<sup>13</sup>-д заасан бүрэн эрхийн дагуу

<sup>12</sup> Аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэргэдээ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн хороотой байна

<sup>13</sup> боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшилийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;

БШУС-ын 2013 оны А/309 дүгээр тушаалаар 2016-2017, 2017-2018 оны, БСШУСС-ын 2018 оны А/425 дугаар тушаалаар 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын чанарын үнэлгээ хийх журмыг тус тус баталжээ. БСШУСС-ын 2018 оны А/425 дугаар тушаалаар баталсан журмын 3.1.15-д тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ гэж шинэ заалт оруулсан боловч шалгуурыг батлаагүйгээс Дархан сумын 12 дугаар сургууль захирлын баталсан “Тусгай хэрэгцээт боловсролын үнэлгээний журам”-аар сурагчдыг үнэлж байна.

Мөн дээрх тушаалд Хилийн чанад дахь олон улсын хөтөлбөртэй сургуулийн чанарын үнэлгээг хийх эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

1.1.2. Салбарын яамнаас баталсан сургалтын бодлого хөтөлбөр, төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго, зорилттой уялдсан байна.

1.1.2.1. Салбарын яам холбогдох боловсролын салбарт ажиллагсдын санал, дүгнэлтэд үндэслэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулжээ.

Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг БСШУСС-ын 2019 оны А/492 дугаар тушаалаар сайжруулан боловсруулж баталсан бөгөөд үүнд “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” сэдэвт багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, “Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан санал, дүгнэлт, Монголын багш нарын VII дугаар их хурлын 2019 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэсэн байна.

1.1.2.2. Салбарын яамны бодлого, хөтөлбөр харилцан уялдаатай байна.

УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он”-ыг баталж, Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1<sup>14</sup>-д заасан боловсролын хөгжлийн стратегийг Бага, дунд боловсролын тухай хуулийн зорилгод нийцүүлэн боловсруулжээ. Дээрх бодлогын 2-т “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын стратегийн зорилтыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх гэж заасан хэдий ч Монгол Улсын Их Хурлаас жил бүр баталдаг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016, 2017, 2018, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилгыг бүрэн тусгаагүй байна.

Мөн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг БШУС-ын 2014 оны А/240 дүгээр тушаалаар “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, БСШУС-ын 2016 оны А/302 дугаар тушаалаар “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, эдгээрийг сайжруулан БСШУСС-ын 2019 оны А/492 дугаар тушаалаар “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр”, БСШУС-ын 2016 оны А/275 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлого”-ыг тус тус баталжээ. Дээрх хөтөлбөрүүдийн зорилго, зорилт нь Бага, дунд боловсролын тухай хуульд заасан зорилготой уялдсан байна.

<sup>14</sup> Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино.

## 1.2. Төрийн өмчийн сургуулийн хүчин чадал 26 хувиар хэтэрсэн байна.

1.2.1 Хамран сургалтын хувь нэмэгдэж, төрийн өмчит сургуульд нэг ангид ногдох хүүхдийн тоо хэтэрсэн байна.

1.2.1.1. Аймгийн ИТХ-аас төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөөг батлан, биелэлтийг дүгнэсэн байна.


Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.2-т “орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 13 тоот тогтоолоор “Аймгийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролыг 2014-2020 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г баталжээ.

Зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр аймгийн БСУГ-ын дарга батлан, ажлын гүйцэтгэлийг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дүгнэн үнэлгээ, зөвлөмж өгдөг ч стратеги төлөвлөгөөний биелэлтийн “Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт”-ийг дүгнээгүй байна.

1.2.1.2. ЕБС-ийн хамран сургалтын хувь нэмэгдэж, төрийн өмчит сургуульд нэг ангид ногдох хүүхдийн тоо хэтэрсэн байна.

Дархан-Уул аймагт 2016-2019 оны хичээлийн жилд 3 ээлжээр хичээллэж байгаа ЕБС байхгүй.

Дүрслэл №1



Аймгийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд 17,623 хүүхдийн хүчин чадалтай 27 төрийн болон хувийн хэвшлийн ЕБС үйл ажиллагаа явуулсан нь сургуулийн насны хүүхдийн 88 хувийг хамруулах хүчин

чадалтай байна.

Хүснэгт №1

### Дархан-Уул аймгийн ЕБС-д сурч буй хүүхдийн тоог хүчин чадалд харьцуулсан үзүүлэлт

Хичээлийн жил	Төрийн өмчийн ЕБС-ийн хүчин чадал	Төрийн өмчийн ЕБС-д сурч буй хүүхдийн тоо	Зөрүү	Хувийн өмчийн ЕБС-ийн хүчин чадал	Хувийн өмчийн ЕБС-д сурч буй хүүхдийн тоо	Зөрүү
2016-2017	14,343	17,783	(3,440)	3,180	1,591	1,589
2017-2018	14,343	17,988	(3,645)	3,180	1,727	1,453
2018-2019	14,343	18,380	(4,037)	3,280	1,922	1,358
Дундаж	<b>14,343</b>	<b>18,050</b>	<b>(3,707)</b>	<b>3,213</b>	<b>1,747</b>	<b>1,467</b>

Дээрх хүснэгтээс харахад төрийн өмчийн сургуулийн хүчин чадлын хэтрэлт дунджаар 3,707 сурагч буюу 26 хувь байхад хувийн өмчийн сургууль хүчин чадлынхаа 55 хувийг ашиглаж байна.

Төрийн өмчийн сургуульд дунджаар 36-46, хувийн сургуульд 18 хүүхэд суралцаж, анги дүүргэлт харилцан адилгүй байгаа нь БСШУС, НХХС, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тоот тушаалын хавсралт 4-т “Анги дүүргэлтийг бага ангид 30-35 /багийн салбар бүлэгт 20-оос доошгүй/ дунд, ахлах ангид 32-35, ... байхаар зохион байгуулна” гэж зааснаас 2-11 хүүхдээр хэтэрсэн байна. Тухайлбал:

- Оюуны ирээдүй цогцолбор сургууль 2-6 хүүхэд;
- Од цогцолбор сургууль 2-6 хүүхэд;
- 9 дүгээр сургууль 2-4 хүүхэд;
- 15 дугаар сургууль 2-11 хүүхэд;
- 16 дугаар сургууль 2-4 хүүхдээр тус тус хэтэрчээ.

Мөн сургуулийн хүчин чадлыг бүрэн ашиглаагүй, зарим анги, бүлэг дунджаар 4-10 сурагчтай, ахлах ангид суралцагч байхгүй байгаа нь ЕБС-ийн үлгэрчилсэн дүрмийн 2.10-т “..... батлагдсан норм, нормативыг баримтлан анги, бүлэг дүүргэлтийг зохион байгуулна” гэж заасантай нийцээгүй. Тухайлбал:

- 1 дүгээр сургууль ахлах анги;
- 6 дугаар сургуулийн ахлах анги;
- 11 дүгээр сургуулийн ахлах анги;
- 12 дугаар сургуулийн ахлах ангийн анги дүүргэлт хангалтгүй байна.

Хамран сургах тойргийн бус сурагч ихтэй 9, 15, “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулиудын эцэг эхээс авсан судалгааны “багшлах боловсон хүчин буюу чадварлаг багштай” асуулт 56 хувийг эзэлсэн байна.

### 1.2.1.3. Шинээр баригдах сургуулийн барилгыг үндэслэлтэй төлөвлөжээ.

Дархан-Уул аймгийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролыг 2014-2020 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд нийт 2,610 хүүхдийн суудалтай 4 сургуулийг шинээр барихаар тусгажээ. Үүнд:

- 2015-2016 онд 960 суудалтай сургууль /15 дугаар баг 14 дүгээр хороолол/;
- 2017-2018 онд 450 суудалтай бага сургууль /малчин баг хөтөл хороолол/;
- 2018 онд 540 суудалтай сургууль /3 дугаар хороолол/;
- 2019 онд 960 суудалтай сургууль /11 дүгээр хороолол/ тус тус төлөвлөжээ.

Төлөвлөгөөнд тусгасан багуудад сургуулийн барилгын хүчин чадал 54-111 хувиар хэтэрсэн байгаа тул төлөвлөлт үндэслэлтэй болсон байна.

Аймгийн БСУГ-аас Дархан сумын 15 дугаарт багийн нутаг дэвсгэрт 7.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 960 хүүхдийн сургуулийн барилгыг Азийн хөгжлийн банкны төслийн хөрөнгө оруулалтаар бариулах саналыг төслийн багийнханд хүргүүлсэн байна.

1.2.2 Барилгын ашиглалтын хугацаа дууссан ЕБС-ийн барилгуудад их завсар хийгдээгүй байна.

1.2.2.1. Ерөнхий боловсролын зарим сургууль сургалтын үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, зориулалтын барилга байгууламжгүй байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар ерөнхий боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 18, хувийн 9 сургууль байна.

Төрийн өмчийн сургуулиудад 15 жилээс дээш насжилттай нийт 13 сургууль байгаагаас хамгийн өндөр насжилттай 6 сургууль байна.

Хүснэгт №2

**Барилгын насжилт өндөртэй сургуулийн барилга**

№	Сургууль	Барилга ашиглалтад орсон он	Ашиглалтын жил	Хүчин чадал хүүхдийн тоогоор
1	1 дүгээр сургууль	1977	43	920
2	9 дүгээр сургууль	1976	44	964
3	11 дүгээр сургууль А байр	1978	42	240
4	14 дүгээр сургууль Б байр	1969	51	190
5	16 дугаар сургууль	1965	55	965
6	Од цогцолбор А, Б байр	1963	57	1,928

Насжилт өндөртэй ЕБС-ийн барилгуудад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Японы буцалтгүй тусламж “Өвсний үндэс” хөтөлбөр, байгууллага, эцэг эхийн хандив зэрэг санхүүжилтээр урсгал болон хэсэгчилсэн засварууд хийгдэж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Ерөнхий боловсролын сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах, зориулалтын барилга байгууламж, эзэмшил болон эдэлбэр газаргүй, сургалтын барилга байгууламжийг түрээсээр ашиглаж байгаа дараах сургуулиуд байна. Тухайлбал:

*Төрийн өмчийн ерөнхий боловсролын:*

- 16 дугаар сургууль ОХУ-ын эзэмшлийн сургуулийн байранд түрээсээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг;
- 30 дугаар сургууль эзэмшил болон эдэлбэр газаргүй;

*Хувийн өмчийн ерөнхий боловсролын:*

- 22 дугаар сургууль өөрийн эзэмшил болон эдэлбэр газаргүй, зориулалтын байргүй;
- 19 дүгээр сургууль эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашигладаггүй, зориулалтын байргүй;
- “Союз” сургууль эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашигладаггүй;
- “Шинэ алхам” сургууль эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашигладаггүй, зориулалтын байргүй;
- “Цайхун” сургууль эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашигладаггүй, зориулалтын байргүй байгаа нь БТХ-ийн 42.1, 42.3, 42.5, 42.6<sup>15</sup>, БДБТХ-ийн

<sup>15</sup> БТХ-ийн 42.1-т “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”, 42.3 “Цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйл болон суралцагчийн эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэндийн

20.2.9<sup>16</sup>-т заасантай, Зам тээвэр хот байгуулалтын Сайдын 2011 оны 305 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-тэй тус тус нийцэхгүй байна.

1.2.2.2. ЕБС-ийн барилгын ашиглалтын хугацаа дууссан сургуулийн барилгад их засвар хийгдээгүй байна.

*“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хандивын хөрөнгөөр 2016-2019 онд хийгдсэн засварын судалгаа”-аас үзэхэд аймгийн ЕБС-иудад нийт 945.1 сая төгрөгөөр хэсэгчилсэн засварыг хийж иржээ. Засварын ажлын нийт санхүүжилтийн 52 хувь нь гадаадын тусламж болон байгууллага, эцэг эхийн хандив, 35 хувь нь УТХО-т, үлдсэн нь ОНТХО, ОНХСан эзэлж байна. /хавсралт №3-өөс үзнэ үү/*

Харин урсгал засварыг сургууль өөрийн нөөц боломж болон төсөвт хуваарилагдаж ирсэн хөрөнгийн хэмжээгээр гүйцэтгэж иржээ.

Барилгын ашиглалтын хугацаа дууссан, их засвар хийгээгүй нь “Боловсролын тухай” хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>17</sup>, “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНБД 13-04-03/<sup>18</sup>”-д заасантай нийцээгүй хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- Дархан сумын 1 дүгээр сургуулийн дээврээс борооны ус нэвтэрснээс 3 дугаар давхрын баруун жигүүрийн анги танхимыг сургалтад ашиглах боломжгүй, аянга зайлуулагч байхгүйгээс цахилгааны гэмтэлтэй;
- Дархан сумын 15 дугаар сургуулийн дээврээс борооны ус нэвтэрснээс 3 дугаар давхрын зарим анги танхимыг сургалтад ашиглахад хүндрэлтэй болсон;
- Дархан сумын 16 дугаар сургуулийн дээврээс усны нэвтрэлт үүсдэг учраас ангийн гэрэл шатах;
- Дархан сумын “Од” цогцолбор сургуулийн А байрны дээврээс борооны ус нэвтэрдэг, дулааны шугамын хэвийн ажиллагаа алдагддаг;
- Хонгор сумын 14 дүгээр сургуулийн спорт заалны дулаан хадгалалтын хэм алдагдсан;
- Орхон сумын 8 дугаар сургуулийн сурагчдын дотуур байрны барилгыг Мэргэжлийн хяналтын газраас ашиглах боломжгүй дүгнэлт 2013 онд гаргасан боловч одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-ийн эзэмшил газарт барилга байгууламж барьж, сургалтын орчинд сөргөөр нөлөөлсөн зүйл байхгүй.

*болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж мөрдүүлнэ”, 42.5-т “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана”, 42.6-т “Боловсролын сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна”*

<sup>16</sup> БДБТХ-ийн 20.2.9-т “багш, суралцагч, ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх”  
<sup>17</sup> БТХ-ийн 42 дугаар зүйл 42.1-т “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”

<sup>18</sup> “БНБД 13-04-03 “урсгал засвар хийх хугацаа 3-5 жил, их засвар хийх хугацаа 15-20 жил

### 1.2.2.3. БСУГ-аас сургуулийн сургалтын орчныг үнэлж, “Сургалтын орчны гэрчилгээ” олгож байна.

Аймгийн БСУГ нь “ЕБС-ийн сургалтын орчны шалгуур үзүүлэлт, стандарт шаардлага хангасан кабинетыг гэрчилгээжүүлэх журам”-ыг мөрдөн аймгийн БСУГ-ын даргын 2017 оны А/66 тоот тушаалаар томилсон ажлын хэсгийн дүгнэлтээр нийт 15 сургуулийн 344 анги кабинетэд “Сургалтын орчны гэрчилгээ” олгожээ. Үүний 45 буюу 13 хувь нь хими, физик, биологи, технологи, 43 буюу 12 хувь нь математик, мэдээлэл зүй, 88 буюу 26 хувь нь монгол хэл, гадаад хэл, 26 буюу 8 хувь нь түүх нийгмийн ухаан, газарзүй, 16 буюу 5 хувь нь биеийн тамирын заал, дуу хөгжим, зураг зүй, 127 буюу 37 хувь нь бага анги байна.

Дээрх сургалтын орчны үнэлгээнд зөвхөн төрийн өмчийн сургуулиуд хамрагджээ.

### 1.2.2.4. ЕБС-ийн гадаад болон дотоод орчин хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан эрсдэлийн үнэлгээг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7-т “Цэцэрлэг, сургуулийн гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно” гэж заасны дагуу хөдөлгөөний нягтрал ихтэй зам талбай сургуулийн ойр орчинд гэрэлтүүлэг, замын тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийлгэж, “хүүхэд болгоомжил” тэмдэглэгээг явган хүний гарц бүр дээр байрлуулж, “сургуулийн цагдаа” замын хөдөлгөөний олон нийтийн хяналт эцэг эхийн эргүүлийг ажиллуулж ирсэн байна.

Мөн байгууллага эцэг, эхийн хандив тусламжаар сургуулийн орчмын бүсийг камержуулах ажлыг бүрэн хийжээ.

ЕБС-ийн ойр орчимд хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламж, үйлдвэрлэлийн газар байхгүй боловч Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14<sup>19</sup>-т заасны дагуу утаат тамхи худалдан борлуулдаг Дархан сумын 5 дугаар багт байрлах “Хүслэн золбоот” ХХК-ийн “Хүслэн”, 6 дугаар багт байрлах “Шинэ гэгээ” ХХК-ийн “Гэгээ” дэлгүүрүүд нь ГХБХБГ-ын кадастрын зургаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн зай дотор байрлаж байсан байна. Зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөгджээ.

### 1.2.2.5. Дархан-Уул аймагт улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016-2019 онд шинээр ЕБС-ийн барилга баригдаагүй.


Дархан-Уул аймагт улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016-2019 онд шинээр ЕБС-ийн барилга баригдаагүй учраас тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн ирээгүй болно.

<sup>19</sup> Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.7.14-т “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах”



### 1.2.2.6. ЕБС-иудад ирсэн хөрөнгийн нийлүүлэлт, хуваарилалтын талаарх бүртгэл судалгаагүй байна.

Дүрслэл №2



БСШУСЯ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн сан, Дэлхийн зөн болон Койка ОУ-ын байгууллага, гадаад дотоод, эцэг эх, төгсөгчдийн хандив тусламжаар 2016 - 2019 онд нийт 1,682.8 сая

төгрөгийн хөрөнгө нийлүүлэгджээ. Үүний 734.7 сая төгрөг нь тоног төхөөрөмж, 473.5 сая төгрөг нь тавилга эд хогшил, 474.6 сая төгрөг нь сургалтын хэрэглэгдэхүүн байна. /Хавсралт №4-аас үзнэ үү/

Аудитаар ерөнхий боловсролын 1, 2, 6, 8, 9, 11, 14, 15, 22 сургуулиудад шалгалт хийхэд хими болон физикийн лабораторигүй, зарим хичээлийн хэрэглэл хангалтгүй, технологийн хичээлийн техник хэрэгсэл хүрэлцээгүй, дадлагын газар байхгүй, ухаалаг самбарын ашиглалт муу, проекторын ламп шатсан байгаа нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>20</sup>, Бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.6, 20.2.9<sup>21</sup>-тэй нийцэхгүй байна.

Одоогоор аймгийн хэмжээнд ЕБС-ийн сурагчдад 2 хүүхдийн автобус үйлчилж байна.

ЕБС-иудад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний нийлүүлэлт, хуваарилалтын талаарх бүртгэл аймгийн БСУГ-т нэгдсэн судалгаа байхгүй, насжилт өндөртэй, ашиглалтын хугацаа дууссан сургуулийн барилгыг их засварт оруулах талаар эрэмбэлээгүй, тухайн ажлыг хариуцсан мэргэжилтэн удаа дараа солигдсон зэрэг нь аудитын ажилд хүндрэлтэй байлаа.

### 1.2.3 Зарим мэргэжлийн багшийн хүрэлцээ дутагдалтай байна.

#### 1.2.3.1. ЕБС-ийн байгууллагад зарим мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй байна.

Дархан-Уул аймагт нийт 27 ерөнхий боловсролын сургууль байгаагийн 18 төрийн өмчийн, 9 төрийн бус өмчийн сургууль байна. Аудитад хамрагдаж буй хичээлийн жилүүдэд нийт 80,124 хүүхэд суралцжээ.

<sup>20</sup> БТХ-ийн 42 дугаар зүйл 42.1-т “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”

<sup>21</sup> Бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх”, 20.2.6-т “суралцагчийн авьяас, чадварыг хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх”, 20.2.9-т “багш, суралцагч, ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх”

Хүснэгт №3

ЕБС-д ажиллаж буй багшийн тоо

Хичээлийн жил	Өмчийн хэлбэр	Ажиллавал зохих багш	Үндсэн багш
2016-2017	Төрийн	873	868
	Хувийн	183	144
<b>Дүн</b>		<b>1,056</b>	<b>1,012</b>
2017-2018	Төрийн	890	880
	Хувийн	188	146
<b>Дүн</b>		<b>1,078</b>	<b>1,026</b>
2018-2019	Төрийн	904	885
	Хувийн	195	170
<b>Дүн</b>		<b>1,099</b>	<b>1,055</b>
2019-2020	Төрийн	916	895
	Хувийн	218	195
<b>Дүн</b>		<b>1,134</b>	<b>1,090</b>


Хүснэгтээс харахад аймгийн нийт мэргэжлийн боловсон хүчний 82-85 хувийг төрийн өмчийн, 15-18 хувийг төрийн бус өмчийн сургуулийн багш эзэлж байна.

2019-2020 оны байдлаар багш нарын боловсролын түвшин нь дипломын боловсролтой 74 буюу 7 хувь, бакалаврын зэрэгтэй 769 буюу 70 хувь, магистрын зэрэгтэй 246 буюу 23

хувийг тус тус эзэлж байна.

Статистик мэдээгээр ерөнхий боловсролын сургуулиудад давхардсан тоогоор Хятад, Англи, Орос, Солонгос хэлний болон бусад мэргэжлийн 44 багш шаардлагатай байгаагаас 2019 оны хичээлийн жилд 52 хувийг хувийн сургууль эзэлж байна.

Дүрслэл №3



Аудитаар нийт 23 сургуулийн удирдах ажилтнаас санал асуулга авахад 11 сургууль мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, 12 сургууль мэргэжлийн боловсон хүчин хангалттай гэж хариулжээ. Хөгжим, дизайн технологи, орос хэл, математик, хими, газар зүй, физик, тусгай хэрэгцээт боловсролын багш, бага ангийн багш зэрэг мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгаа нь хөдөө суманд ажиллах сонирхолгүй, орон сууц, нийгмийн асуудал хүндрэлтэй, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургууль, төгсөгчид зах зээлийн эрэлтийн чанарыг хангахгүй, багшийн цалин бага, ачаалал их зэрэг шалтгаанаар өөр мэргэжлээр ажиллах хандлага их байна.

Судалгаагаар аймгийн хэмжээнд 12 сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бөгөөд үүнээс 2 сургуульд нийт 7 анги, бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Тус сургуулиудад тусгай хэрэгцээт боловсролын багшийн хүрэлцээ дутмаг байна. Дунд, ахлах ангийн нийт 885 багш байгаагаас англи хэлний дунд түвшний мэдлэгтэй багш 449, англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй багш 182 байна.

Одоогийн байдлаар БСУГ-т бага анги, англи хэл, математик, түүх нийгмийн ухаан, дуу хөгжим зэрэг мэргэжлийн 72 багш нөөцөд бүртгэлтэй байгаа нь

мэргэжлийн багш нарыг эрэлт хэрэгцээтэй байгаа холбогдох сургуулиудад мэдээлэх ажил хангалтгүй байна.

### 1.2.3.2. Ерөнхий боловсрол олгож байгаа сургуулиудын 44 хувь нь багшийн хөгжлийн төвгүй байна.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролыг 2014-2020 онуудад хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд багш нарын тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2017 оны 55 тоот тогтоолоор “Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг /2017-2020 он/ баталсан байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 зорилт, 27 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс жил бүр үнэлж дүгнэжээ.

Дэд хөтөлбөр хэрэгжих хугацаанд БСШУСЯ-наас 2017 онд Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд Төрийн өмчийн сургуулиудын багш нарт зөөврийн компьютер өгч, wifi, интернет ашиглах, тасралтгүй хөгжих нөхцөл байдлаар хангаж өгчээ.

ЕБС-аас багш хөгжлийн төвтэй эсэх судалгааг авахад 15 сургууль “Тийм”, 12 сургууль “Үгүй” гэсэн нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна” гэх заалт хэрэгжихгүй байна. Аудитын хүрээнд 8 сургуулийг түүвэрт хамруулан анги кабинеттай танилцахад 2 дугаар сургууль, 15 дугаар сургууль, “Оюуны ирээдүй” цогцолбор сургууль, Багшийн хөгжлийн төвийн кабинет тохижуулан ажиллаж байна. Харин бусад сургуулиуд нь багшийн хөгжлийн төвтэй гэх боловч багш, сургалтын менежерийн өрөөг багш хөгжлийн төв нэрээр ашиглаж байгаа нь хуулийн 7 дугаар зүйлийн 7.3<sup>22</sup>, 14 дүгээр зүйлийн 14.1.2<sup>23</sup> дахь заалтууд хэрэгжихгүй байна.

### 1.2.3.3. Ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй удирдах албан тушаалтныг томилсон байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2019 оны 01-А/358 тоот захирамжийн дагуу ЕБС-ын захирлын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталжээ. Түүвэрт хамрагдсан төрийн өмчийн 12 сургуулийн захирлын ажлын байрны тодорхойлолтод заасан “ЕБС-д үндсэн орон тоонд 5-аас доошгүй жил багшилсан байх” шалгуурыг хангасан эсэхийг шалгахад шаардлагад нийцээгүй 2 захирлыг түр томилсон байна.

Иймд ажлын байранд тавигдах шаардлага хангасан иргэнийг томилж байх албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд тус тус хүргүүлэв.

Аудитаар төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудын багш ажилчдын хувийн хэргийг түүвэрлэн шалгахад төрийн албан хаагчийн анкет дутуу бөглөсөн, төгссөн мэргэжлийн дипломын хуулбар, өмнө нь ажиллаж байсан ажлын туршлага гэх мэт материал бүрдүүлэлт хангалтгүй байна. Иймд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам-ыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

<sup>22</sup> Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна

<sup>23</sup> багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх

1.2.3.4. "Салбарын яам ЕБС-ын хүний нөөцийн бодлого оновчгүй, бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна уу? /тэгш хүрэлцээ/

Орон нутагт хамааралгүй.

1.3 Сургуулиудын үйл ажиллагааны санхүүжилтийг бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.3.1. Төсвийг бодитой төлөвлөж, төлөвлөсөн дүнгээр хуваарилсан байна.

1.3.1.1. Төсвийг өмнөх оны суралцагчдын тоонд үндэслэн төлөвлөжээ.

ЕБС-ийн төсвийн төслийг нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар санхүүжих төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалттай холбогдсон харилцааг боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1<sup>24</sup>, 40.2<sup>25</sup>, 40.3<sup>26</sup> дахь заалт, Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор зохицуулахаар заасан.

Хүснэгт №4

**Төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа**

/сая төгрөгөөр/

№	Он	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	Төсвийн төсөлд өгсөн санал	Харьцуулсан байдал			Харьцуулсан байдал	
				Төсвийн төсөлд өгсөн санал / Өмнөх оны төсвийн гүйцэтгэл/		Батлагдсан төсөв	Төсвийн төсөлд өгсөн санал / Батлагдсан төсөв/	
				Мөнгөн дүн	Хувь		Мөнгөн дүн	Хувь
1	2016	6,574.9	16,750.8	10,175.9	154.7	6,072.3	(10,678.5)	63.7
2	2017	6,166.4	16,225.9	10,059.5	163.1	13,663.9	(2,562.0)	15.8
3	2018	13,568.3	15,899.8	2,331.5	17.2	15,175.5	(724.3)	4.5
4	2019	14,295.9	18,821.5	4,525.6	31.6	18,799.0	(22.5)	0.1
<b>Нийт дүн</b>		<b>40,605.5</b>	<b>67,698.0</b>	<b>27,092.5</b>	<b>66.7</b>	<b>53,710.7</b>	<b>13,987.3</b>	<b>20.7</b>

ЕБС-иуд нь төсвийн төслөөр 2016 онд 16,750.8 сая, 2017 онд 16,225.9 сая, 2018 онд 15,899.8 сая, 2019 онд 18,821.5 сая төгрөгийн хувьсах зардлын санхүүжилт авахаар санал хүргүүлснээс 2016 онд 6,072.3 сая буюу 63.7 хувь, 2017 онд 13,663.9 сая буюу 15.8 хувь, 2018 онд 15,175.5 сая буюу 4.5 хувь, 2019 онд 18,799.0 сая буюу 0.1 хувиар тус тус бууруулан санхүүжилтийг баталсан байна.

2016 оны төсвийн төслийг цалин хөлс, нэмэгдэл урамшлыг засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолоор үндсэн цалинг 15 хувиар нэмэгдүүлсэнтэй холбогдуулан өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 10,175.9 сая буюу 154.7 хувиар өсгөн төлөвлөжээ.

Иймд УИХ-ын 2019 оны 21, Засгийн газрын 2014 оны 75, 183, 2018 оны 382, 2019 оны 24, 275, 276, 277 тогтоол батлагдсантай холбоотойгоор төрийн албан хаагчийн цалин хөлс, үр дүнгийн урамшуулал, НДШ зэрэг зардлууд нэмэгдсэн тул

<sup>24</sup> Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ.

<sup>25</sup> Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

<sup>26</sup> Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

бодит шаардлагатай цалин хөлс, НДШ-ийг тооцож, төсвийн төслийг баталж байгаа нь Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Харин төсвийн төслийг нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар тооцохдоо төрийн бус өмчийн сургуулиудын хувьсах зардлыг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор тооцож олгож байгаа тул төрийн өмчийн болон төрийн бус өмчийн хувьсах зардал харилцан адилгүй төлөвлөгдөж байна.

**1.3.1.2. Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг харилцан адилгүй хуваарилж байна.**

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн сургуулиуд батлагдсан төсвийн хуваарийн дагуу төрийн өмчийн 18 сургуульд 2016 онд 16,842.9 сая, 2017 онд 18,531.4 сая, 2018 онд 17,855.7 сая, 2019 онд 20,763.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Аудитаар сүүлийн 4 жилийн дунджаар суралцагчдын статистик тоог, хуваарилсан санхүүжилттэй тулгахад төрийн өмчийн сургуулиудыг шаардлагатай бодит цалин хөлсөөр тооцож, нэг сурагчид ногдох хувьсах зардлыг аймгийн төвийн сургуульд 0.7-0.8 сая, бусад сумын сургуульд 1.0-2.0 сая, тусгай хэрэгцээт боловсролын сургуульд 2.7 сая төгрөгөөр тооцон төсвийг хуваарилжээ. Харин Төрийн бус өмчийн сургуульд Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын дагуу санхүүжилтийг тооцон хуваарилж нэг суралцагчид ногдох зардалд дунджаар 0.3-0.4 сая төгрөг хуваарилсан байна. /Хавсралт №5, 6-аас үзнэ үү/

**1.3.1.3. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.**

Дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар санхүүжих төсвийн төлөвлөлттэй холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2<sup>27</sup>, 43.2.1<sup>28</sup>, 43.2.2<sup>29</sup> дахь заалт, Засгийн газрын 2012 оны 94, 2016 оны 242 дугаар тогтоолуудаар зохицуулж байна.


Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 580 хүүхдийн хүчин чадалтай 6 сургуулийн дотуур байр үйл ажиллагаагаа явуулж байна.

<sup>27</sup> Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршилыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

<sup>28</sup> оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин буюу амьжиргааны түвшин доогуур суралцагчийг дотуур байраар хангах;

<sup>29</sup> ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байранд төлбөргүй суух

**Дотуур байранд хамрагдсан хүүхдийн тоо**



Дүрслэлээс харахад Хонгор сумын 14 дүгээр сургуулийн дотуур байр 80 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд дунджаар 122 хүүхэд хамрагдаж дотуур байрны хүчин чадлаас хэтэрсэн байна. Харин Шарын гол сумын 2 дугаар сургууль 2018 онд 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр ашиглалтад орсон бөгөөд дунджаар 51 хүүхэд хамрагдсан байна.

**Дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ**

/сая төгрөгөөр/

№	Он	БСУГ-ын төсвийн төсөл	Аудитаар тооцоолсон дүн				Зөрүү
			Цалин	Ажил олгогчийн төлөх шимтгэл	Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал	
1	2016	224.1	117.4	12.9	8.5	138.8	85.3
2	2017	191.4	164.6	18.1	8.7	191.4	-
3	2018	199.9	171.8	18.9	9.2	199.9	-
4	2019	199.6	169.2	18.6	9.1	196.9	2.7
<b>Нийт</b>		<b>815.0</b>	<b>623.0</b>	<b>68.5</b>	<b>35.5</b>	<b>727.0</b>	<b>88.0</b>

Тайлант хугацаанд БСУГ-ын баталгаажуулсан төсвийн төслийг Засгийн газрын 2012 оны 94, 2016 оны 242 дугаар тогтоолуудтай тулган шалгахад 2016 онд дотуур байранд хамрагдах нийт хүүхдийг ЕБС-ийн 6 настай хүүхэд амьдардаг дотуур байрны төсвөөр тооцсон, цалингийн зардлаас гадна үр дүнгийн урамшууллыг тооцож нэмснээр 85.3 сая, харин 2017, 2018 онуудад зөрчил илрээгүй бөгөөд 2019 онд ажил олгогчийн НДШ-ийг 2.5 сая төгрөгөөр тус тус илүү төсөвлөжээ. Энэ нь дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ 2016 оноос хойш шинэчлэгдээгүй бөгөөд тус хугацаанд цалин хөлс, НДШ-ийн хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор төсвийг нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2,315 төгрөгөөр тогтоосны дагуу төсвийн төслийг боловсруулжээ.

1.3.1.4. Аймгийн ЕБС-ийн төсөвт ном, сурах бичиг худалдан авах зардал төлөвлөгддөггүй байна.

МУЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолоор ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг батлахдаа бусад хувьсах зардлыг баталсан /бичиг хэрэг, ном хэвлэл, дотоод албан томилолт зэрэг 10 нэр төрлийн зардал/ боловч уг зардлыг хэрхэн тооцож хуваарилах талаар зохицуулалт, аргачлал байхгүй байна. ЕБС-ийн суралцагчдад шаардлагатай сурах бичгийг БСШУЯ-аас аймгийн хэмжээнд хуваарилсны дагуу БСУГ-аас суралцагчдын тоо, анги бүлгийн тооноос хамааран сургуулиудад хуваарилж байна.

Төсвийн төсөлд ЕБС-ийн суралцагчдад шаардлагатай ном, сурах бичгийг худалдан авах зардал төлөвлөгдөхгүй байна.

#### 1.3.1.5. Шаардлагатай гарын авлага, сургалтын бусад хэрэглэгдэхүүний төсвийг төлөвлөхөд нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэхгүй байна.

ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг “бусад хувьсах зардал”-аас хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг хэрхэн тооцож, хуваарилах талаар аргачлал байхгүй байна. Тус зардлын төсвөөр багш, ажилчид шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн бусад хэрэглэгдэхүүнийг төсөвтөө багтаан зарцуулж байна.

Гарын авлага, сургалтын үзүүлэн болон нас онцлогт тохирсон бусад хэрэглэгдэхүүнийг худалдан авч болох боломжит зардлууд нь хүрэлцээгүй, зардлын төлөвлөлт нь нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэгдээгүй байна.

#### 1.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

##### 1.3.2.1. Хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож олгоогүй байна.

Аудитаар хувьсах зардлын санхүүжилтийн олголтыг давтан тооцоолж, тогтоосон норм нормативыг мөрдлөг болгон ажилласан эсэхийг шалгахад хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын хувьсах зардлыг зөрүүтэй тооцож олгожээ. Харин төрийн өмчийн ЕБС-иудын хувьсах зардлыг баталсан аргачлалын дагуу хүүхэд өдрөөр хянаж, санхүүжилт олгох боломжгүй байна.

Хүснэгт №6

#### Хувьсах зардлын судалгаа

Д/д	Сургуулийн нэр	2016-2019 онд зөрүүтэй олгосон санхүүжилт /сая.төг/
1	19-р сургууль	(87.6)
2	Турк 21-р сургууль	(114.9)
3	24-р ахлах сургууль	32.6
4	АЖБ 26-р сургууль	8.1
5	29-р ахлах сургууль	0.3
6	22-р ахлах сургууль	(20.3)
7	Наран сургууль	5.3
8	Монгол Оюу ахлах сургууль	(97.8)
9	Союз ахлах сургууль	(15.7)
10	Цайхун ахлах сургууль	1.4
11	Шинэ алхам	(57.7)

Энэ нь хувьсах зардлын санхүүжилтийн тооцоог хийхдээ Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан аргачлалын 3.4-д заасныг мөрдөөгүй, суралцагчдын тоог буруу тооцоолсонтой холбоотой байна.

Харин төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын хувьсах зардлыг баталсан аргачлалын дагуу хүүхэд өдрөөр хянаж, санхүүжилт олгох

боломжгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх тухай” аргачлалын 4.5-д “Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь төрийн албан хаагчдын цалин түүнтэй холбоотой нэмэгдэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрчлөлт орж өссөнтэй холбоотой байна. Иймд Засгийн газрын 242 дугаар тогтоолоор баталсан “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх тухай” аргачлалыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### 1.3.2.2. ЕБС-ийн дунд болон ахлах бүлгийн хүүхдүүдийн 50-72 хувь нь сурах бичгийн дутагдалтай байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд төрийн болон хувийн өмчийн ЕБС-д нийт 20.0 мянга орчим сурагч суралцаж байна.

Аймгийн БСУГ-аас гаргадаг статистик мэдээг нэгтгэхэд дунд болон ахлах ангийн сурагчдын 50-72 хувьд нь сурах бичиг хүрэлцдэггүй гэсэн үзүүлэлт гарчээ.

Хүснэгт №7

#### Сурах бичгийн дутагдал

Хичээлийн жил	Бүлэг	Хүүхдийн тоо		Эзлэх хувь
		Суралцаж байгаа	Сурах бичиггүй	
2016-2017 он	Бага	9,782.0	1,352.0	13.8
	Дунд	5,718.0	3,126.0	54.7
	Ахлах	3,364.0	2,396.0	71.2
	<b>Нийт</b>	<b>18,864.0</b>	<b>6,874.0</b>	<b>46.6</b>
2017-2018 он	Бага	10,279.0	722.0	7.0
	Дунд	5,924.0	2,977.0	50.3
	Ахлах	3,025.0	2,170.0	71.7
	<b>Нийт</b>	<b>19,228.0</b>	<b>5,869.0</b>	<b>43.0</b>
2018-2019 он	Бага	10,811.0	351.0	3.2
	Дунд	6,408.0	3,516.0	54.9
	Ахлах	2,733.0	1,992.0	72.9
	<b>Нийт</b>	<b>19,952.0</b>	<b>5,859.0</b>	<b>43.7</b>

Эх сурвалж: БСУГ-ын 2016-2019 оны статистик мэдээ

Харин 2019-2020 оны хичээлийн жилд БСШУЯ-наас түрээсийн ном хөтөлбөр хэрэгжүүлснээр сурах бичгийн дутагдал бага бүлэгт 3, дунд бүлэгт 13, ахлах бүлэгт 19 хувь болж өмнөх хичээлийн жилүүдээс 10-54 хүртэл хувиар буурчээ.

### 1.3.2.3. Төсөв, хөрөнгө батлагддаггүйгээс багшийн хөгжлийн төв үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.

Бүх шатны боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш нарын хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зорилгоор Монгол Улсын Их хурлаас 2018 онд “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуулиар бүх шатны боловсролын байгууллага багшийн хөгжлийн төвтэй байна, нийт хувьсах зардлын 2 хүртэл хувийг үйл ажиллагаанд нь зарцуулахаар баталжээ. Гэвч багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зориулсан төсөв батлагддаггүйгээс багш нар ажлын байран дээрээ тасралтгүй суралцах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй нь Багшийн



хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын нийт 27 сургуулийн 40.7 хувь нь багшийн хөгжлийн төвгүй, багшийн хөгжлийн төвтэй сургуулиуд нь шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж дутмаг байлаа. Иймд багшийн хөгжлийг дэмжих хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу тухай жилийн төсөвт нь багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг тусгаж өгөх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-ийн 27 сургуульд мянга гаруй багш ажиллаж байгаагаас багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 2016 онд 889, 2017 онд 2,600, 2018 онд 993, 2019 онд 1,692 багш хамрагджээ. БСШУЯ-аас аймгийн БСУГ-т СӨБ болон ЕБС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зориулж 107.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 80.1 сая төгрөгийг ЕБС-ийн багш нарын сургалтад зарцуулжээ.

Хүснэгт №8

**Багшийн мэргэжил дээшлүүлэх зардлын гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

Он	БСШУЯ-аас санхүүжүүлсэн	ЕБС-ийн сургалтад зарцуулсан
2016 он	20.8	12.8
2017 он	24.2	16.8
2018 он	37.5	23.9
2019 он	25.0	26.5
<b>Нийт дүн</b>	<b>107.6</b>	<b>80.1</b>

Багшийн мэргэжил дээшлүүлэхэд зориулж олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд: Бага боловсролын сургалтын

менежерүүдийн сургалтыг зохион байгуулахаар “Мэдээлэл зүйн олимпиад” НҮТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 0.9 сая төгрөг шилжүүлсэн боловч сургалт зохион байгуулагдаагүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

**1.3.2.4. Аймгийн БСУГ хувьсах зардлын санхүүжилтийг олгохдоо хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.**

Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан бөгөөд үйл ажиллагааны журмыг Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталжээ.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс дээрх хууль, журмын дагуу төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, түүнд хяналт тавих хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллажээ. Харин аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хувьсах зардлын санхүүжилтийг олгохдоо хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Цаашид Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын дагуу сар бүр хүүхэд өдрөөр хянаж, санхүүжилтийг олгож байх зүйтэй юм.

1.3.2.5. Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой үүссэн авлага, өглөгийн тооцоог баталгаажуулж тайланд тусгаагүй байна.

Аудитаар үдийн цай хөтөлбөрийн санхүүжилт авсан сургуулиудын 50 хувь буюу 13 сургуулийг түүвэрт хамруулж шалгахад 2016 онд 387.1 сая, 2017 онд 396.6 сая, 410.4 сая, 428.6 сая, нийт 1,622.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг давтан тооцож, хүүхдийн тоог анги удирдсан багшийн болон жижүүр багшийн журналтай тулгахад Дархан сумын 1 дүгээр сургууль 2016-2017 онд 1.8 сая, 24 дүгээр сургуульд 2016-2019 онд нийт 2.7 сая төгрөг илүү тооцож олгожээ.

Төрийн өмчийн сургуулиуд үдийн цай хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн санхүүжилтийг олгохдоо хүүхэд өдрөөр тооцож олгож байгаа боловч жилийн эцэст үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Тодруулбал: Төрийн сангийн гүйлгээ эрт хаах, батлагдсан төсвийг татуулахгүй байх зэрэг шалтгаанаар суралцагчдын тоог нэмэгдүүлж үдийн цай хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид илүү санхүүжилт олгон, дараа оны санхүүжилтээс хасаж тооцдог нийтлэг зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэсэн заалттай холбоотой бөгөөд нөгөө талаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ”* гэж заасантай зөрчилдөж байна. Иймд үдийн цайны хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй хагас бүтэн жилээр үүссэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгаж байхыг төсвийн шууд захирагч нар анхаарч ажиллах зөвлөмж өглөө.

Аудитаар бодит хүүхдийн тооноос илүү санхүүжилт авсан 24 дүгээр сургуульд 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Цаашид хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо хүүхдийн тоонд хяналт тавьж, гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх шаардлагатай байна.

1.3.2.6. Тэтгэлэгт төслийн санхүүжилтээр худалдаж авсан хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Дэлхийн банкны дэмжлэгээр БСШУЯ-аас хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” тэтгэлэгт төсөлд төрийн өмчийн 14 сургууль хамрагдаж нийт 289.3 сая төгрөгийн санхүүжилтээр сурагчдын танин мэдэхүйн боловсролд ашиглагдах үзүүлэн бүхий анги, кабинетын тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага, тоног төхөөрөмж зэргийг худалдан авсан байна.

БСШУС-ын тушаал, үүрэг чиглэлийн дагуу аймгийн БСУГ болон БСШУЯ-ны хамтарсан бүрэлдэхүүн сургуулийн тэтгэлэгт төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 3 удаагийн хяналт мониторинг хийж, сайн гэж дүгнэжээ.

БСШУЯ-аас олгосон санхүүжилт

/сая төгрөгөөр/

№	Сургуулийн нэр	Санхүүжилт				Нийт
		2016 он	2017 он	2018 он	2019 он	
1	1-р сургууль	4.9	7.1	1.4	-	13.4
2	2-р сургууль	4.9	1.2	-	-	6.1
3	4-р сургууль	4.9	1.2	-	-	6.1
4	6-р сургууль	5.9	-	-	-	5.9
5	8-р сургууль	6.0	-	-	13.1	19.1
6	9-р сургууль	6.0	5.9	1.5	-	13.4
7	11-р сургууль	4.8	6.9	1.4	15.0	28.1
8	12-р сургууль	6.2	6.0	1.4	-	13.6
9	14-р сургууль	5.9	6.0	1.5	51.0	64.4
10	15-р сургууль	4.9	7.1	1.5	-	13.5
11	18-р сургууль	4.9	1.2	-	27.5	33.6
12	“Жигүүр” цогцолбор	4.8	7.1	1.5	-	13.4
13	“Од” цогцолбор	9.8	8.3	1.5	13.6	33.2
14	“Оюуны ирээдүй” цогцолбор	9.8	2.4	-	13.2	25.4
<b>Дүн</b>		<b>83.7</b>	<b>60.4</b>	<b>11.7</b>	<b>133.4</b>	<b>289.2</b>

Аудитаар тэтгэлэгт төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтыг шалгахад Хонгор сумын 14 дүгээр сургууль сургалт зохион байгуулах, үзүүлэн хийх зардалд 3.6 сая төгрөг зарцуулсан боловч хийгдээгүй, 0.5 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн биетээр байхгүй, 0.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд зөрүүтэй тусгасан байв. Мөн Хонгор сумын 11 дүгээр сургууль 1.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байлаа.

Дээрх зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

1.3.2.7. Ерөнхий боловсролын сургуулиудын 20 хүрэхгүй хувь нь сургууль хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрмээ боловсруулсан байна.

БСШУС, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 тоот тушаалаар “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”, мөн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2<sup>30</sup>, Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2<sup>31</sup>-д хандив, тусламжийг боловсролын байгууллагын санхүүгийн эх үүсвэрийн нэг хэсэг байхаар хуульчилжээ.

Дээрх хамтарсан тушаалаар баталсан үлгэрчилсэн дүрмийн дагуу санд хөрөнгө хүлээн авах, зарцуулах, тайлагнах дүрмээ боловсруулж, мөрдлөг болгон ажиллаж байгаа Дархан сумын 9, 15, 18, “Од” цогцолбор, “Оюуны ирээдүй”


<sup>30</sup> Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно

<sup>31</sup> Боловсролын байгууллага нь улсын төсөв, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

цогцолбор сургуулиуд байгаа бөгөөд 2016-2019 онд нийт 169.4 сая төгрөгийн хандив тусламж авч зарцуулалтыг тайлагнасан байна.

Аудитад хамрагдаж байгаа хугацаанд төрийн өмчийн 12 сургууль гадаад, дотоодын байгууллага, иргэд, эцэг эх, асран хамгаалагчдаас нийт 631.5 сая төгрөгийн хандив, тусламж хүлээн авчээ. Хандив тусламжаар авсан хөрөнгийн 71.2 хувь нь үндсэн хөрөнгө, 19.0 хувь нь мөнгө, үлдсэн 9.7 хувь нь бараа материал болон бусад хөрөнгө байна.

Дүрслэл №5



Ерөнхий боловсролын нийт 27 сургуулиас 5 сургууль буюу 20 хүрэхгүй хувь нь сургууль хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэмтэй байгаа нь хууль эрх зүйн орчин нөхцөл бүрдсэн боловч сургуулийн зөвлөл, удирдах зөвлөлийн үүрэг оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд сургуулийн удирдах зөвлөл болон сургуулийн зөвлөл дээрх үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн сургууль хөгжүүлэх сангийн дүрмээ боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ БИЕЛҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

2.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан боловсрол эзэмшүүлж, сургалтын чанарт жил бүр үнэлгээ хийж байна.

2.1.1 Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг явуулжээ.

2.1.1.1. Зарим хувийн сургуулиуд заавал судлах судлагдахуун хичээлийг орохгүй байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус ЕБС-иуд боловсролын стандарт, үндэсний хэмжээнд мөрдөх цөм хөтөлбөрийн дагуу сургалтын төлөвлөгөө, хуваарийг хичээлийн жилийн бүтэц, өөрийн сургуулийн онцлогтой уялдуулан боловсруулан ажиллаж байна.

Аудитын хамрах хугацаанд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус ЕБС-даас түүвэрлэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарийг БСШУС-ын 2014 оны А/240, 2015 оны А/220, 2016 оны А/275, БСШУСС-ын 2018 оны А/453 тоот тушаалын дагуу боловсруулан заавал судлах стандарт цагийн хичээлийг бүрэн гүйцэд эзэмшүүлж байгааг шалгалаа.

Аудитаар 11, 8, 12, Шинэ алхам, 6 дугаар сургуулиуд стандарт цагаараа хичээлийг гүйцэд ороогүй, 24, 19 дүгээр сургуулиуд заавал судлагдах хичээлийг орхигдуулсан зөрчлүүд илэрлээ.

Хүснэгт №10

### Хичээл, судлагдахууныг стандарт цагаар гүйцэд ороогүй сургуулиудыг нэгтгэн үзүүлсэн хүснэгт

Сургуулийн нэр	Стандарт цаг			Багшийн заасан цаг			Зөрүү		
	2016-2017	2017-2018	2018-2019	2016-2017	2017-2018	2018-2019	2016-2017	2017-2018	2018-2019
6-р сургууль	13,323	11,781	12,531	14,404	11,539	13,125	1,081	(242)	594
8-р сургууль	18,959	17,898	17,679	18,820	17,772	16,402	(139)	(126)	(1,277)
11-р сургууль	12,270	12,270	12,270	12,235	11,853	11,872	(35)	(417)	(398)
12-р сургууль	11,962	11,962	12,189	12,977	13,909	11,092	1,015	1,947	(1,097)
18-р сургууль	41,547	41,204	37,506	44,337	46,178	36,916	2,790	4,974	(590)
Шинэ алхам	-	4,229	6,978	-	4,169	6,205	-	(60)	(814)

Стандарт цагийн хичээлийг дутуу орсон сургуулиудын хувьд мэргэжлийн хичээл заах багш байхгүй, бүлгийн хүүхдийн тоо хүрэхгүйгээс ангийг тараасан, БСШУСС-ын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны А/25 тоот тушаалаар аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчин гарсантай холбогдуулан сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон, бүлгийн хүүхдийн тооноос хамаарч группээр оруулалгүй нийлүүлж оруулсан зэргээс шалтгаалан стандарт цагийн тооцоо дутуу гарсан гэж үзэхээр байна.

Алслагдсан сумдын ЕБС-д бүлгийн тоо цөөн, бага ангийн болон мэргэжлийн хичээлийн багш хүрэлцээгүй, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилладаггүй нь голлох шалтгаан болоод байна. Иймд заавал судлах хичээлийг орохгүй байгаа сургуулиудад хяналт тавьж ажиллах талаар БСУГ-т зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар ЕБ-ын 24 дүгээр сургууль 2016-2018 оны хичээлийн жилд 7-9 ангид орос хэлний хичээл ордоггүй байсан, 19 дүгээр сургууль нь одоог хүртэл 7-9 дүгээр ангиудад орос хэлний хичээлийг огт ороогүй байна. Энэ нь БСШУС-ын 2015 оны А/220, БСШУСС-ын 2018 оны А/453, 2019 оны А/491 тоот тушаалын хавсралтад заасан дунд ангийн сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн үйл ажиллагааг бүрэн явуулаагүйд аймгийн БСУГ хяналт тавьж ажиллаагүй нь Бага дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>32</sup>, Боловсролын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1.4</sup><sup>33</sup>, 28<sup>1.1.10</sup><sup>34</sup> дахь заалтуудыг зөрчиж байгаа тул албан шаардлагыг хүргүүлээ.

#### 2.1.1.2. Сургалтад нэмэлт материал, гарын авлага ашиглаж байгаа нь сурагчийн цүнхний жинд нөлөөлж байна.

Аймгийн БСУГ, сургуулиудын удирдлага, менежерүүдтэй уулзахад сурагчдын цүнхний жингийн талаар авч хэрэгжүүлсэн ажил байхгүй байлаа.

Сурагчийн цүнхний жинд дасгал ажлын ном, багшийн бэлтгэсэн гарын авлага, бүтээлийн хавтас, солих гутал, үдийн цайны аяга, таваг нөлөөлж байна. Үүнийг зарим сургууль сурагчийн цүнхний жинг багасгах зорилгоор хичээлийн хуваарьт зохицуулалт хийх, бага цагаар ордог хичээлийн номыг ангид үлдээх, хүүхэд бүрийг шүүгээтэй болгох зэрэг зохион байгуулалт хийсэн сайн жишээ байна. Тухайлбал: Төрийн өмчийн 1, 9, төрийн бус өмчийн “Цайхун”, “Шинэ алхам” зэрэг сургуулиуд дээрх зохион байгуулалтыг хийжээ.

#### 2.1.1.3. Аймгийн БСУГ нь гүнзгийрүүлсэн сургалт явуулдаг сургуулиудыг 3 жил тутамд аттестатчилж, сургалтын чанарт үнэлгээ өгч ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 10 сургууль, 8 төрлийн хичээлээр гүнзгийрүүлсэн сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Аудитаар 24 дүгээр сургууль гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийг батлуулаагүй, “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийн хугацаа дууссан, 9 дүгээр сургууль гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөргүй, аймгийн БСУГ-аас гүнзгийрүүлсэн сургалт явуулж байгаа сургуулиудыг 3 жил тутамд аттестатчилж, сургалтын чанарт үнэлгээг хийгээгүй зэрэг зөрчил илэрлээ.

БСШУС-ын 2002 оны 333 дугаар тушаалаар баталсан “ЕБС-д гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ын 2.1.1<sup>35</sup>, 3.13<sup>36</sup>-т заасныг зөрчиж байгаа тул аймгийн БСУГ-т хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Гадаад боловсролын хөтөлбөрөөр үйл ажиллагаа явуулж байгаа “Союз” сургууль нь 2003 оноос эхлэн сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд “Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг аймгийн Засаг дарга олгож иржээ. Уг тусгай зөвшөөрөлд Монгол улсад мөрдөгдөж байгаа бага, дунд, суурь боловсролын

<sup>32</sup> Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь суралцагчид бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын агуулгыг заавал эзэмшүүлнэ

<sup>33</sup> “Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх

<sup>34</sup> Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх...

<sup>35</sup> Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт явуулах сургалтын төлөвлөгөө, хичээлийн киррикулумыг боловсруулан аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвөөр батлуулсан байхаас гадна, багшлах бүрэлдэхүүн, нэмэлт сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэгслэгдэхүүнийг мөн төвөөр хянуулж, шаардлагад нийцэх, эсэх талаар дүгнэлт гаргуулсан

<sup>36</sup> Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт явуулах сургалтыг Боловсролын тухай хуулийн 28.1.8-д заасны дагуу 3 жил тутамд аттестатчилж, сургалтын чанарт үнэлгээ өгч баталгаажуулна

стандарт, төлөвлөгөө, хөтөлбөртэй байх, орос хэлний гүнзгийрүүлсэн сургалтыг 1-12 ангид явуулахаар тусгасан байтал одоог хүртэл 1-4 ангиуд нь орос хэл дээр бүх хичээлийг явуулж байна.

Иймд сургуулийн үйл ажиллагаа Бага, дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>37</sup>, Боловсролын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1.2</sup><sup>38</sup>, 28<sup>1.1.4</sup><sup>39</sup>, 28<sup>1.1.10</sup><sup>40</sup> дахь заалтууд, тусгай зөвшөөрөлтэй тус тус нийцэхгүй байгаа тул БСУГ-т хяналт тавьж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэв.

**2.1.2. Аймгийн БСУГ-аас сургуулиудын сургалтын чанарт хөндлөнгийн үнэлгээ жил бүр хийж байна.**

**2.1.2.1. Аймгийн МСҮТ, насан туршийн боловсролын төвд боловсролын чанарын үнэлгээний судалгаа хийгээгүй байна.**

Боловсролын чанарын үнэлгээний судалгаанд манай аймгийн хувьд түүврээр 2017-2019 онуудад тус бүр 4 сургууль хамрагдсан байна. Үүнд:

Хүснэгт №11

**БҮТ-ийн түүвэрт хамрагдан судалгаанд оролцсон сургуулиудын жагсаалт**

Хамрагдсан сургуулийн нэр	2017 он	2018 он	2019 он
9-р сургууль	✓		
18-р сургууль	✓		
“Од” цогцолбор	✓		
“Оюуны ирээдүй” цогцолбор	✓	✓	✓
16-р сургууль			✓
15-р сургууль		✓	
1-р сургууль		✓	
4-р сургууль		✓	✓
14-р сургууль			✓

Эндээс харахад түүвэрт хамрагдаж байгаа сургуулиуд нь бүгд төрийн өмчийн сургуулиуд байгаа бөгөөд манай аймгийн хэмжээнд насан туршийн боловсролын төв болон хувийн хэвшлийн сургуулиуд хамрагдаагүй байна.

Боловсролын үнэлгээний төвөөс 2017 онд авсан шалгалтын дүнг аймгийн хэмжээнд шалгагдсан сургуулиудаар нэгтгэн харууллаа.

Хүснэгт №12

**Аймгийн хэмжээнд шалгагдсан 5 дугаар ангиудын шалгалтын дүнг сургуулиудаар жагсаасан хүснэгт**

№	Сургуулийн нэр	Математик	Монгол хэл	Байгаль шинжлэл	Нийт дундаж дүн
1	9-р сургууль	54.4	50.3	47.8	50.8
2	18-р сургууль	50.0	32.6	50.2	44.3
3	“Од” цогцолбор	52.5	38.8	54.6	48.6
4	“Оюуны ирээдүй” цогцолбор	52.7	41.8	50.3	48.3
-	Аймгийн дундаж	52.4	40.9	50.7	48.1
-	Улсын дундаж	48.6	36.6	49.2	44.8

5 дугаар ангийн хувьд манай аймгийн нийт шалгалтын дундаж 48.1 дүнгээр улсын хэмжээнд 7 дугаарт жагсаж улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

<sup>37</sup> Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь суралцагчид бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын агуулгыг заавал эзэмшүүлнэ

<sup>38</sup> Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох

<sup>39</sup> Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх

<sup>40</sup> Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх...

**Аймгийн хэмжээнд шалгагдсан 9 дүгээр ангиудын шалгалтын дүнг сургуулиудаар жагсаасан хүснэгт**

№	Сургуулийн нэр	Математик	Монгол хэл	Байгаль шинжлэл	Нийгмийн ухаан	Нийт дундаж дүн
1	9-р сургууль	26.1	49.3	30.1	31.2	34.2
2	18-р сургууль	19.9	48.6	27.4	34.8	32.7
3	Од цогцолбор	27.0	50.5	36.1	35.5	37.3
4	Оюуны ирээдүй цогцолбор	35.3	59.5	37.6	40.1	43.1
<b>Аймгийн дундаж</b>		27.1	51.9	32.8	35.5	36.9
<b>Улсын дундаж</b>		27.6	47.4	30.7	38.5	36.1

9 дүгээр ангийн шалгалт өгсөн дээрх сургуулиуд 2 хичээлээр улсын дунджаас дээгүүр оноо авч нийлбэр дүнгээр улсын хэмжээнд 11 дүгээрт жагсаж, харин 12 дугаар ангийн хувьд 9 хичээлээр шалгалт өгч нийт дундаж оноо 35.4 буюу улсын хэмжээнд 13 жагсан улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байна.

2018 оны хувьд түүвэрт хамрагдсан сургуулиудын дүнгийн нэгтгэлийг улсын дундажтай харьцуулав.

**Түүвэрт хамрагдан шалгагдсан 5 дугаар ангиудын шалгалтын дүнг улсын дундажтай харьцуулсан хүснэгт**

Сургуулийн нэр	Математик	Монгол хэл	Байгаль шинжлэл
<b>Аймгийн дундаж</b>	45.6	38.1	47.7
<b>Улсын дундаж</b>	41.2	37.6	46.4

5 дугаар ангийн шалгалтад хамрагдсан 4 сургуулийн хувьд судлагдахуун бүрээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдэн 10 дугаарт жагссан байна.

**Түүвэрт хамрагдан шалгагдсан 9 дүгээр ангиудын шалгалтын дүнг улсын дундажтай харьцуулсан хүснэгт**

Сургуулийн нэр	Математик	Монгол хэл	Байгаль шинжлэл	Нийгмийн ухаан	Нийт дундаж дүн
<b>Аймгийн дундаж</b>	24.6	47.6	34.2	41.6	37.1
<b>Улсын дундаж</b>	26.1	49.4	33.9	38.0	36.85

9 дүгээр ангийн шалгалт өгсөн дээрх сургуулиуд 2 хичээлээр улсын дунджаас дээгүүр оноо авч нийлбэр дүнгээр улсын хэмжээнд 13 дугаарт жагссан байна.

**Түүвэрт хамрагдан шалгагдсан 12 дугаар ангиудын шалгалтын дүнг судлагдахуун бүрээр нь харьцуулсан хүснэгт**

Шалгалт авсан хичээлийн нэр	1-р сургууль	15-р сургууль	4-р сургууль	“Оюуны ирээдүй” ЦС	Аймгийн дүн /гүйц.хувь/	Орон нутгийн дундаж	Улсын дундаж
Математик	42.4	14.8	16.5	27.1	24.1	26.8	27.5
Монгол хэл	45.9	47.8	48.4	53.8	51.3	51.7	53.2
Англи хэл	48.8	36.2	37.4	50.0	44.6	41.6	46.0
Нийгэм	32.8	28.6	42.2	43.3	38.6	41.7	42.5
Хими	18.5	6.0	0	26.3	23.3	26.3	25.6
Физик	26.0	24.1	0	23.1	23.8	22.6	23.1
Биологи	39.6	32.3	24.3	35.6	34.0	32.2	32.2
Газар зүй	39.5	0	0	46.0	45.2	39.2	42.5



12 дугаар ангийн хувьд орон нутгийн дунджаас химийн хичээлээс бусад нь дээгүүр үнэлэгдсэн ч, улсын дунджаас биологийн хичээлээс бусад судлагдахуун хичээлийн дүн доогуур үнэлэгдсэн байна.

БСШУСС-ын 2019 оны А/35 тоот тушаалаар 2019 онд Боловсролын үнэлгээний төвөөс “Чанарын үнэлгээний судалгаа”-г бага боловсролоос 3 дугаар ангийг математик, монгол хэл, хүн орчин, хөгжмийн хичээлээр түүвэрлэн, суурь боловсролоос 9 дүгээр ангийн бүх сурагчдаас математик, монгол хэл, англи хэл, физикийн хичээлээр, бүрэн дунд боловсролоос 10 дугаар ангийг математик /заавал, сонгон/, монгол хэл, биологи, газар зүйн хичээлээр түүвэрлэн шалгалтыг авахаар шийдвэрлэн, шалгалтыг авч үнэлгээг гаргасан байна.

Үнэлгээг сургуулиар, судлагдахуун бүрээр нь гарган аймгийн дундаж, улсын дундажтай харьцуулсан байгаа нь өөрийн аймгийн түүвэрт хамрагдсан сургуулиудын түвшнийг харахад илүү амар болсон байна.

Хүснэгт №17

**Аймгийн дунджийг улсын дундажтай  
харьцуулан нэгтгэсэн хүснэгт**

№	Боловсролын түвшин	Аймгийн дундаж	Улсын дундаж
1	Бага	48.7	49.9
2	Суурь	38.1	37.1
3	Бүрэн дунд	31.1	31.9

Бага боловсролын хувьд монгол хэлний шалгалтын дүн /аймгийн дундаж 36.1/ улсын дунджаас /37.4/ доогуур, математикийн шалгалтын аймгийн дундаж /54.9/ нь улсын дунджаас /53.3/ дээгүүр, хүн орчны шалгалтын аймгийн дундаж /64.0/ нь улсын дунджаас /68.9/ доогуур, хөгжмийн шалгалтын аймгийн дундаж /39.3/ улсын дунджаас /39.6/ дээгүүр үнэлэгдсэн байна.

2019 оны хувьд суурь боловсролын 9 дүгээр ангийн цөм хөтөлбөрөөр хичээллэж буй сургуулиудыг бүгдийг хамруулах шийдвэр гаргасантай холбоотойгоор аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус ерөнхий боловсролын 22 сургуулийн суралцагчдыг шалгалт, судалгаанд хамруулсан байна.

Бүрэн дунд боловсролын хувьд 10 дугаар ангийн сурагчдаас 4 хичээлээр шалгалт, судалгааг авчээ.

Хүснэгт №18

**Түүвэрт хамрагдсан сургуулиудын шалгалтын дүнг  
судлагдахуун бүрээр харуулсан хүснэгт**

Сургуулийн нэр	Математик-1	Математик-2	Монгол хэл	Газар зүй	Биологи	Ерөнхий дундаж
14-р сургууль	26.0	18.7	52.0	26.0	30.4	30.4
4-р сургууль	21.4	19.8	64.1	23.7	33.0	34.8
16-р сургууль	20.2	19.9	45.3	23.3	27.3	26.6
“Оюуны ирээдүй” цогцолбор сургууль	27.3	25.5	53.0	23.7	31.9	33.1

Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр авч байгаа чанарын үнэлгээнд хийсэн судалгааны тайланг аймгийн БСУГ болон сургуулийн удирдлагуудад албан ёсоор хүргүүлдэггүй, судалгааны дүнг мэдээлдэггүй учраас сурлагын чанарыг ахиулах талаар төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх боломжгүй байна.

Төрийн болон төрийн бус ЕБС-ийг багш хичээлийн жилийн эхэнд суралцагч бүрийн гарааны үнэлгээ тогтоож, сурлагын түвшнийг тогтоодог. Улирал, хагас, бүтэн жилээр сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвараар дотоод хяналт хийж, үнэлгээнд дүн шинжилгээ хийн эцэг эхэд зөвлөгөө өгөн хоцорч болзошгүй сурагчдыг эрт илрүүлэн хичээлийн явцад хоцрогдлыг арилгах ажлыг зохион байгуулж ажилладаг байна.

Аймгийн БСУГ-аас 2017-2018 оныг “Боловсролын чанарыг сайжруулах жил” болгон зарлаж, “Ээлжит хичээлийн үр өгөөж- Улирлын аян”-ыг зохион байгуулжээ. Тус аяны хүрээнд “Өөрийн брэнд арга зүй” -гээрээ шалгарсан 84 багшийг өргөмжлөн, тэдний бүтээлээр “Шилдэг арга зүйн мэдээлэл судалгааны төв” байгуулан аймгийн багш шилдэг арга зүйтэй багш нарын материалаас санаа авч өөрийн үйл ажиллагаандаа эх сурвалжтай тусгах боломжтой болжээ.

Мөн дээрх хичээлийн жилд “ЕБС-ийн багшийн сургалтын чанар үр дүнг индексээр дүгнэх журам”-ыг санаачлан боловсруулжээ. “Багшийн ур чадвар, массын сургалтын жигд амжилт, ээлжит хичээлийн үр өгөөж, бүтээлч сонирхолтой хичээлийн эзлэх хувь зэрэг үзүүлэлт”-ээр 1024 багшаас 39 багш шалгарч, индекс нь БСШУСЯ-аас дэвшүүлсэн “Үр дүнд суурилсан үнэлгээний шинэчлэл”-ийг Дархан-Уул аймаг бодитойгоор хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна. Судлагдахуун бүрийн стандарт хангалтын түвшнийг тогтоосноор аймгийн дунджийг суурь үзүүлэлт болгон гаргаж чаджээ.

Аймгийн хэмжээнд Индекс- I буюу багшийн өөрийн үнэлгээний шалгалтыг давхардсан тоогоор 106565 суралцагчаас 14 судлагдахуун хичээлээр авч стандарт хангалт 61.7%, гүйцэтгэлийн хувь 58.5%-тайгаар үнэлэгджээ.

Индекс- II шалгалтыг бага ангийн сурагчдаас 2, дунд ахлах ангийн сурагчдаас 14 хичээлээр авахаар зохион байгуулж 27 сургуулиас 24 сургуулийн давхардсан тоогоор 4264 бүлгийн 795 багш, 108957 суралцагч уг шалгалтад хамрагдсан байна. Насан туршийн боловсролын төв, 30 дугаар сургуулиуд шалгалтад хамрагдаагүй.

Индекс- III шалгалтыг бага ангийн сурагчдаас 2, дунд ахлах ангийн сурагчдаас 15 хичээлээр 16 сургуулийн 16773 сурагч, 121 багш хамрагдсан. Нийт хамрагдсан багш нарын 57 нь аймгийн дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

Индекс 2 шалгалтыг индекс 1 шалгалтын дүнтэй харьцуулахад аймгийн дундаж үзүүлэлт 5.5 хувиар, индекс 3 шалгалтыг индекс 2 шалгалттай харьцуулахад дүн 9.5 хувиар тус тус өссөн байна.

Тухайн хичээлийн жилд төрийн болон төрийн бус ЕБС-иудаас “Индекс -1, 2, 3” гэсэн шалгалтуудыг баталсан төлөвлөгөөний дагуу шалгалтыг авсан ч дараа онд нь “Амжилтын эзэд” нэртэйгээр хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг бас зохион байгуулсан байна. Энэ хөндлөнгийн үнэлгээний шалгалт нь аймгийн БСУГ-ын 2018-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил байсан бөгөөд энэ нь БСШУСС-ын 2018 оны А/425 тоот тушаалаар баталсан “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 3.17<sup>41</sup>-д

<sup>41</sup> Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна

заасныг зөрчсөн тул сурагчдаас авах хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөндөө тусгаж ажиллахыг аймгийн БСУГ-т зөвлөмжөөр хүргүүлэв.

Аймгийн БСУГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 16-ны А/26 тоот тушаалаар төрийн болон төрийн бус ЕБС-ын сургалтын чанар, судлагдахуун бүрийн мэдлэг чадварын түвшинд хяналт тавих, цаашид сайжруулах арга зүйг боловсруулахад зориулан “**Амжилтын эзэд**” хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг зохион байгуулсан байна. Уг шалгалтаар 15 судлагдахуун хичээлээр дунд, ахлах ангиас түүвэрлэн, бага ангийн сурагчдаас чадамжийн шалгалтыг авч дүнг нэгтгэсэн байна. Аймгийн хэмжээнд уг шалгалтад 53795 сурагч хамрагдаж, гүйцэтгэлийн чанар 68.5%-тай дундажлагдсан байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд элсэлтийн ерөнхий шалгалтыг сургууль бүр удирдамж боловсруулан зохион байгуулан ажилладаг байна.

2016-2019 онуудын сургууль бүрийн элсэлтийн ерөнхий шалгалтад авсан дундаж оноог тухайн оны аймгийн дундаж, улсын дундажтай харьцуулан харуулбал:

Хүснэгт №19

**Сургууль бүрийн авсан элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дунджийг харуулсан хүснэгт**

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Аймгийн дундаж	508.1	517.4	516.2	503.7
2	Улсын дундаж	501.0	501.4	503.3	499.0
3	Улсын хэмжээнд эзэлсэн байр	4	3	4	8

Элсэлтийн ерөнхий шалгалтаар 2016 онд 13, 2017 онд 15, 2018 онд 14, 2019 онд 6 сургууль улсын дунджаас дээгүүр оноо авчээ.

**2.1.2.2. Аймгийн БСУГ-аас сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсэд үнэлгээ хийгээгүй байна.**

Аймгийн БСУГ, ЕБС-иуд сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тусгайлан үнэлгээгүй байна.

Аудитаар 14 төрийн болон төрийн бус ЕБС-ийн удирдлагуудаас сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар тодруулахад:

- Аймгийн төвөөс алслагдсан зарим баг, сумын иргэдийн амьдралын түвшин доогуур, эцэг эхийн боловсролын түвшин, хүүхдэдээ тавих анхаарал халамж сул, өвчлөл ихтэй;
- Орхон, Хонгор сум тариалалтын бүс нутаг тул хавар, намрын цагуудад эцэг эх нь хүүхдээ ажиллуулах нэрээр хичээл ихээр таслуулдаг;
- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний өөрчлөлтүүд нь багш нар хөтөлбөрөө бүрэн судлах, өөрийн болгох, сурагчдад өгөх жишиг даалгавар, сурах бичгийн агуулга, арга зүйн боловсруулалтыг чанаргүй хийх;
- Сурах бичгийн даалгаврын тавил, сурагчдын хөгжлийг дэмжихүйцээр боловсруулагдаагүй тул багш өөрөө даалгаврын материалыг нэмэлтээр боловсруулахад цаг их зарцуулдаг;

- Шинээр төгсөн ирж буй залуу багш нарын мэдлэг тааруу, тогтвор суурьшилтай ажилладаггүй, хөдөө сумдын сургуульд мэргэжлийн багш дутагдалтай, Дарханаас сумд руу явж ажилладаг;
- Бусад аймаг, сумдаас шилжиж ирэлгүйгээр хүүхдээ айлд байлгах явдал их байдаг;
- Анги дүүргэлт харилцан адилгүй хотын төвийн сургуулиудын ачаалал их, захын болон сумдын сургуулийн бүлгийн тоо цөөн, анги дүүргэлт бага;
- Шарын гол, Хонгор сумын сургуульд казах хүүхдүүд их байдаг бөгөөд Монгол хэл мэдэхгүй сургуульд ордог нь бэрхшээл үүсгэж байгаа талаар ярьж байлаа.

2.2. Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын үр нөлөө харилцан адилгүй байна.

2.2.1 Аймгийн БСУГ-ын ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд хяналт үр нөлөөгүй байна.

2.2.1.1. Дархан-Уул аймагт аудитын хамрах хугацаанд салбарын яамны зүгээс хяналт хийгээгүй байна.

Дархан-Уул аймгийн БСУГ болон ЕБС-иудад 2016-2019 онд салбарын яамны зүгээс хяналт хийгээгүй байна.

2.2.1.2. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн I шатны хэрэгжилтэд салбарын яам хяналт хийж, үр дүнг тооцсон байна.

БСШУЯ, Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээний “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн I шатанд 5 сургууль хамрагдаж 30.0 сая, II шатанд 9 сургууль хамрагдаж 67.1 сая, III шатанд 8 сургууль хамрагдаж 58.8 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн байна.

Уг хөтөлбөрийн I шатны хэрэгжилтэд БСШУЯ-тай хамтран БСГ, II, III шатны хэрэгжилтэд аймгийн БСУГ хяналт тавьж ажиллажээ. Хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийхдээ төслийн үр ашгийг хүртэгчдийн тоо, гарсан үр дүнг тооцож, ололттой болон дутагдалтай талуудыг тодорхойлжээ.

Мөн дээрх төслийн хүрээнд STEM боловсролыг хөгжүүлэх зорилготой сургалтын хэрэглэгдэхүүн, ширээ сандал, ном, номын тавиур, монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичгийг нийлүүлсэн байна. Дархан-Уул аймгийн БСУГ-аас тус хэрэглэгдэхүүнүүдийг ашигласнаар багш, сурагчдад гарч байгаа ахиц дэвшил, шинэлэг санаа, бэрхшээл, анхаарах асуудлууд зэргийг нэгтгэн дүгнэж, үнэлсэн байв.

Дархан-Уул аймагт дээрх төсөл, хөтөлбөрөөс өөр гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

2.2.1.3. Орон нутгийн боловсролын газрын хяналт үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28<sup>1</sup>.1.4-т “Аймаг, нийслэлийн боловсролын газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:... боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх,” 37 дугаар зүйлийн 37.1-д “Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Мөн БСШУС-ын 2003 оны 321 дугаар тушаалаар ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг ашиглан хөндлөнгийн үнэлгээ өгч, жил бүрийн 1 дүгээр сард багтаан БСШУЯ-нд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга нарт үүрэг болгож, БШУС-ын 2013 оны А/315 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.4-т “...*Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих*,...” чиг үүрэг тусгагдсан байна.

Гэтэл Дархан-Уул аймгийн БСУГ нь төрийн болон хувийн хэвшлийн нийт 27 сургуулиас 2016 онд 8, 2017 онд 17, 2019 онд 10 сургуульд хяналт шинжилгээ хийсэн байна. Хяналтыг хийхдээ зөвхөн өөрийн үнэлгээ ирүүлсэн сургуулиудыг тоон ба чанарын шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэж, үнэлгээ өгчээ. Үнэлгээгээр хангалтгүй дүгнэгдсэн сургуулиудад үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр ямар нэгэн албан даалгавар, заавар зөвлөмж өгөөгүй байна.

Харин 2018 онд “Сургалтын хөтөлбөр, арга зүй болон багшийн хөгжил, үнэлгээ” чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулж, сургуулийн удирдах ажилтнууд болон багш нарын түвшинд зөвлөмж боловсруулжээ. Гэвч уг зөвлөмжийн биелэлтийг эргэж хянаагүй байлаа.

**2.2.1.4. Ерөнхий боловсролын сургуулиуд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Ерөнхий боловсролын сургуулийн захирал нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар 20.2.1-т, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасны дагуу боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тайлагнах үүрэгтэй.

Аудитын түүвэрт хамрагдсан сургууль бүр дотоод хяналтын нэгж болон ажилтныг томилон ажиллуулж байгаа бөгөөд 16 сургууль нь өөрийн байгууллагын дотоод хяналт шалгалтыг явуулах журмыг баталсан бол Орхон сумын 8, Дархан сумын 18, “Шинэ алхам” сургуулиуд журам боловсруулаагүй байна.

Ихэнх сургуулиуд хичээлийн жилээр дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө гаргаж, хяналт хийх бүртээ удирдамж боловсруулан ажиллажээ. Харин “Од” цогцолбор сургууль, Хонгор сумын 11 дүгээр сургуулиуд дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй, 30 дугаар сургууль хяналт явуулаагүй, 19 дүгээр сургууль дотоод хяналтын баримт материал ирүүлээгүй болно.

Хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж, албан шаардлага хүргүүлэн, биелэлтийг эргэн шалгаж ажиллажээ.

Харин 1 дүгээр сургууль, Насан туршийн боловсрол төв, Союз сургууль төлөвлөгөөнд тусгасан ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй, Хонгор сумын 11, 14 дүгээр сургууль дотоод хяналтын ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулаагүй байна.

**2.2.1.5. Аймгийн БСУГ-аас болон бусад хөндлөнгийн байгууллагаас сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.**

БСШУС-ын 2015 оны А/302 тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг баталж, түүний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулахыг даалгасан байна.

Аймгийн БСУГ болон бусад хөндлөнгийн байгууллагаас сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

**2.2.1.6. Салбарын яамнаас багш бэлтгэж буй их дээд сургуулийн хөтөлбөр, чанарт хяналт хийгээгүй байна.**

Дархан-Уул аймагт Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Дархан салбар мэдээлэл зүйн болон гадаад хэлний багш, Дархан дээд сургууль бага ангийн багш, англи хэлний багш, дуу хөгжмийн багш, мэдээлэл технологийн багш бэлтгэдэг.

Тус сургуулиуд 2016-2019 онд багш мэргэжлээр нийтдээ 250 оюутан төгсгөжээ.

Хүснэгт №20

**Багш мэргэжлээр төгссөн оюутны тоо**

Хичээлийн жил	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Дархан салбар	Дархан дээд сургууль	Нийт
2016-2017	47	41	88
2017-2018	41	54	95
2018-2019	29	38	67
<b>Дүн</b>	<b>117</b>	<b>133</b>	<b>250</b>

Аудитын хамрах хугацаанд дээрх 2 сургуулийн хөтөлбөр, сургалтын чанарт салбарын яамны зүгээс хяналт хийгээгүй байна.

**2.2.1.7. Сургалтын менежерүүд сургалтын хөтөлбөрт тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Дархан-Уул аймгийн төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын багш нар судлагдахуун, анги нэгдлийн багаараа ажиллаж, цөм хөтөлбөрт нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургалтын менежерээр батлуулан ажиллажээ.

Оюуны ирээдүй цогцолбор сургууль, 9, 28, 29, Шинэ алхам, Шарын гол сумын 2, 6, Орхон сумын 8 дугаар сургуулиудын менежерүүд сургалтын хөтөлбөрийг шалган, үнэлж баримтжуулсан байлаа.

Харин аймгийн БСУГ-ын судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөгөө өгч ажилласан талаар нотлох баримт материал ирүүлээгүй болно.

**2.2.2 Ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт харилцан адилгүй байна.**

**2.2.2.1. Мэргэжлийн байгууллагаас хийсэн хяналт шалгалт үр нөлөөтэй хэрэгжиж байна.**

Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2016-2017 оны хичээлийн жилд МХЕГ-ын даргын нэгдсэн удирдамжаар бүх шатны боловсролын

байгууллагын багшлах боловсон хүчний хангамж, чанарын байдал болон ЕБС-д хууль бус төлбөр, хураамж авч байгаа байдалд тандалт судалгаа хийж, дүнг нэгтгэн, цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлэн ажиллажээ.

Харин 2017-2018 оны хичээлийн жилд төрийн 16, хувийн 8 сургуульд, 2018-2019 оны хичээлийн жилд төрийн 9, хувийн 6 сургуульд хяналт шалгалтыг хийсэн нь Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт сургуулийн 2017-2018 онд 88.9 хувь, 2018-2019 онд 55.5 хувийг эзэлж байна. Энэ нь шалгалтын хамрах хүрээ хангалттай байгааг харуулж байна.

Хүснэгт №21

МХГ-ын хяналт шалгалтын хамарсан хүрээ

Хичээлийн жил	Нийт сургуулийн тоо	Хамрагдсан сургуулийн тоо	Эзлэх хувь
2016-2017	27	27	100.0
2017-2018	27	24	88.9
2018-2019	27	15	55.5

2017-2018 оны хичээлийн жилд хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд 2 удаагийн хяналт шалгалтыг хийж, нийт 431 зөрчил илрүүлснээс 339-ийг нь шалгалтын явцад арилгуулан, бусад зөрчилд хугацаатай 16 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд 40 зөрчил илэрснээс 75 хувийг нь шалгалтын явцад арилгуулж, 25 хувьд нь хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг хянан ажилласан байлаа.

#### 2.2.2.2. Эцэг эхийн зүгээс байнгын үр дүнтэй ажил хийгээгүй байна.

Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Эцэг эх, асран хамгаалагч нь боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал хүсэлт гаргах, ...эрхтэй”, 46.2-т “Хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах, ... үүрэгтэй” бол Бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Захирал нь сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах үүрэгтэй” байна.

Аудитын түүвэрт хамрагдсан сургуулиудын баримт материалтай танилцахад ихэвчлэн эцэг эхчүүд спортын тэмцээн уралдаан, ангийн хурал, АХА тэмцээн, үдийн цайны амталгаанд оролцож, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл сэдвүүдээр сургалтуудад хамрагдсан байлаа.

Иймд ЕБС-ийн удирдлагууд сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөртөө эцэг, эхчүүдтэй хамтран үр дүнтэй ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Харин аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 82 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургууль бүр 2016 оны 09 сараас эхлэн “Сургуулийн цагдаа” ажиллуулж хэвшсэн нь сургуулийн орчинд гэмт хэрэг, ялангуяа зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлсэн сайшаалтай үйл ажиллагаа болжээ.

Холбогдох байгууллагын санал:



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг Аймгийн ЗДТГазрын байр  
Утас/Факс: 7037-7701  
E-mail: darkhanuu@mecs.gov.mn

2020.10.23 № 366  
танай 2020.10.21 -ны № 490 -Г

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж,  
Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын  
2020 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний  
төлөвлөгөөний дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий  
боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д  
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй  
танилцлаа.

Төсөлд өгөх санал, тайлбар байхгүй болно.

ДАРГА

Б.ГАНТУЛГА



**Саналд өгсөн тайлбар:**

Тайлангийн төсөлд санал, тайлбар ирээгүй.



## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Хуульд заасан дүрэм, журам, норм норматив бүрэн батлагдаагүй, зарим эрх зүйн актууд харилцан уялдаагүй байна.
- Төрийн өмчийн сургуулийн барилгын хүчин чадал болон нэг ангид ноогдох хүүхдийн тоо хэтэрч, шинээр баригдах сургуулийн барилга баригдаагүй, их засвар хийгдээгүйгээс хүүхдийн эрүүл, аюулгүй орчин бүрдээгүй байна.
- Хандив тусламжаар ирсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний нийлүүлэлт, хуваарилалтын талаарх бүртгэл аймгийн БСУГ-т нэгдсэн судалгаа байхгүй байна.
- Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, зарим мэргэжлийн багш дутмаг байна.
- ЕБС-иудад багшийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Ажлын байранд тавигдах шаардлагад нийцээгүй удирдах ажилтныг томилсон байна.
- Төрийн албан хаагчийн цалин, цалингийн нэмэгдэл өссөнтэй холбогдуулж Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан аргачлалыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.
- БСШУЯ-аас түрээсийн ном хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр сурах бичгийн дутагдал өмнөх онуудаас 10-54 хувиар буурсан байна.
- Багшийн хөгжлийн дэмжих тухай хууль хэрэгжихгүй байна.
- Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын дагуу сар бүр хүүхэд өдрөөр хянаж, санхүүжилтийг олгоогүй байна.
- Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч ААН-тэй үүссэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Ерөнхий боловсролын сургуулиудын 20 хүрэхгүй хувь нь сургууль хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрмээ боловсруулсан байна.
- БСШУЯ-аас баталсан ЕБС-дын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулж байгаад хяналт тавьж ажиллаагүй байна.
- Аймгийн БСУГ-аас ЕБС-иудад хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг нэвтрүүлсэн нь сургалтын чанар, багшийн ур чадвал, сурагчдын сургалтын амжилтыг нэмэгдүүлэх томоохон ажил болжээ.
- Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд аймгийн БСУГ-аас тавих хяналт үр нөлөөгүй байна.
- Байгууллагын түвшинд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Суралцагчдын эцэг эхийн зүгээс байнгын үр дүнтэй ажил хийхгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

*Аймгийн БСУГ-ын дарга Б.Гантулгад:*

- Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан шинээр баригдах сургуулийн барилгыг эхлүүлэх, шаардлагатай их засварын ажлын төсвийг БСШУЯ-нд хүргүүлэх, батлуулах;
- ЕБС-ийн үлгэрчилсэн дүрмийн 2.10-т заасныг мөрдөж ажиллах;
- ЕБС-иудад ирсэн хөрөнгийн нийлүүлэлт, хуваарилалтын талаар бүртгэл судалгааг хийх;
- Нөөцөд бүртгэлтэй мэргэжлийн багш нарыг ЕБС-ын эрэлт хэрэгцээтэй байгаа холбогдох сургуулиудад мэдээлэл өгөх;
- Хувьсах зардлын санхүүжилтийг олгоходоо Засгийн газрын 242 дугаар тогтоолд заасны дагуу хяналт тавих;
- ЕБС-иудын заавал судлах хичээлийн стандарт цаг, эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг бүрэн олгож байгаа байдалд хяналт тавих;
- Гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөр, сургалтын чанарт дүгнэлт өгч ажиллах,
- Сурагчдаас авах сургалтын чанарын хөндлөнгийн үнэлгээг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллах;
- Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулж, хяналтын үр нөлөөг дээшлүүлэх.

*ЕБС-ийн захирлуудад:*

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах;
- Багш хөгжлийн дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах;
- Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч ААН-тэй үүссэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгаж байх;
- Сургууль хөгжүүлэх сангийн дүрмийг үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн боловсруулж мөрдөж ажиллах;
- Эцэг эхчүүдтэй бүтээлчээр хамтран ажиллах боломжийг судалж, байнгын үр дүнтэй ажил зохион байгуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

2020.10.26

## ХАВСРАЛТУУД:

Хавсралт №1

Боловсролын тухай хуулийн дагуу батлагдаагүй дүрэм, журам, норм норматив

Боловсролын тухай хуулийн зүйл, заалт		Өмнө /одоо хүчингүй болсон/ мөрдөж байсан тогтоол шийдвэрүүд		Одоо мөрдөж байгаа тогтоол шийдвэрүүд /Өмнөх тогтоол шийдвэрүүдийг хүчингүй болгосон/		Илрүүлэлт
16.7	Багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон тоог санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.			<b>Засгийн газрын тогтоол 2012.06.23-ны №180</b>	<b>Багшийн мэргэжил дээшлүүлэх институт байгуулах тухай</b> -Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм /Хавсралт 1/	Хуульд энэ заалтыг 2016.04.14-ний өдөр нэмсэн. БМДИ-ийн дүрэм, бүтцийг салбарын сайд батлахаар заасан байтал дүрмийг ЗГ баталсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх арга зүйн байгууллага нь БМДИ гэж тодорхойлсон заалт байхгүй.
		<b>БШУС-ын тушаал 2014 оны А/24</b>	<b>Тушаалд өөрчлөлт оруулах тухай</b>	<b>БСШУСС-ын тушаал 2018.08.01-ний №А/482 /БШУС-ын 2014 оны А/24 дүгээр тушаалыг хүчингүй болсон/</b>	<b>Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай</b>	
25.6	Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. / <b>гатаан буулгахтай холбоотой асуудал/</b>					Батлаагүй
28.1	<b>Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ</b>					
28.1.23	төрийн өмчийн цэцэрлэг, ЕБС, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах					Хоол хүнсээр хангах нийтлэг журам батлагдаагүй
28.1.24	сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам батлах;	<b>БШУС-ын тушаал 2013.08.09-ны №А/287</b>	<b>Журам шинэчлэн батлах тухай</b> -Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам /Хавсралт/		БСШУЯ-ны 2017.01.27-ны өдрийн 2/789 тоот албан бичгээр хасалт хийсэн	БСШУЯ-ны 2017.01.27-ны өдрийн 2/789 тоот албан бичгээр хасалт хийж хүчингүй болгосон. Шинээр батлагдаагүй.
36.12	<b>Удирдах зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ /Гадаад улстай хамтарсан хэлбэрээр байгуулсан/</b>					
39.12	Төрийн өмчийн ЕБС, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална					Батлаагүй

40.3	Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.					Жил бүр батлаагүй
41.3	Төрийн бус өмчийн ЕБС-ийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг тухайн боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөртэй нь уялдуулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно	<b>Засгийн газрын тогтоол 2012.03.28-ны №94</b>	<b>Зардлын дундаж норматив батлах тухай</b> -ЕБС-ийн нэг суралцагчид бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж норматив /Хавсралт2/	<b>Засгийн газрын тогтоол 2016.05.02-ны №242</b> /Засгийн газрын 2012.03.28-ны 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсарлтыг хүчингүй болгосон/	<b>Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай</b> Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн /Хавсралт 1/ -төрийн болон орон нутгийн өмчит ЕБС-ийн бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ /Хавсралт3/ -ЕБС-ийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ /Хавсралт4/ -төрийн бус өмчийн ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ /Хавсралт5/ -сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ЕБС-ийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал /Хавсралт 6/	Жил бүр батлаагүй
41.4	Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна					Батлаагүй

Боловсролын тухай хууль, түүнд оруулж баталсан бусад хуулиудын харилцан уялдаа

№	Боловсролын тухай хуулийн заалт		Бусад холбогдох хуулийн нэр, заалт		Зөрчил	
1	3.1.9	“хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан иргэнийг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	3.1	Энэ хууль хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.	Харилцан уялдаагүй
2	20.1	Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	15.7.9	-	Ийм заалт байхгүй.
				16.3.3	-	Хүчингүй болсон заалт
3	43.1.8	Ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	7.8	-	Ийм заалт байхгүй.
4	43.4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг Төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална	Төрийн албаны тухай хууль	31.3	Төрийн албан хаагчийг томилох асуудлаар хууль тогтоомж зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно	Харилцан уялдаагүй
5	43.6	Энэ хуулийн 43.1.8-д заасан нэмэгдлийг Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасны дагуу тогтооно.		28.9	-	Ийм заалт байхгүй.
6	43.7	Энэ хуулийн 43.1.4, 43.5-д заасан нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.		30.2	Энэ хуулийн 30.1-д заасан хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна	Харилцан уялдаагүй

Дархан-Уул аймагт 2016-2019 онд төрийн өмчийн сургуулийн барилгад хийгдсэн засварын судалгаа

/сая төгрөгөөр/

№	Он	Сургуулийн нэр	Засварын төрөл	УТХО	ОНТХО	ОНХСан	Бусад	ДҮН
1	2016 он	9-р сургууль	Дээврийн засвар	87.0				171.6
2		18-р сургууль	Спорт заалны цонх сольсон		4.0			
3		6-р сургууль	Цэвэр бохир ус, ариун цэвэрийн өрөөний засвар			56.0		
4		11-р сургууль	Спорт заалны шалны засвар, УБТЗ-ын хандив				24.6	
<b>Дүн</b>				<b>87.0</b>	<b>4.0</b>	<b>56.0</b>	<b>24.6</b>	
1	2017 он	ОИЦ сургууль	Дээвэр засвар	69.9				420.6
2		Од цогцолбор сургууль	Дээвэр засвар	85.2				
3		1-р сургууль	Гадна цэвэр усны шугам, спорт заалны засвар	49.5				
4		18-р сургууль	Ялтсан дулаан солилцуурын засвар	39.3				
5		8-р сургууль	Дотуур байрны засвар, БНСУ-ын Гванжу хотын залуучуудын холбооны хандиваар				11.4	
6		14-р сургууль	Дотуур байрны засвар Өвсний үндэс хөтөлбөр				165.4	
<b>Дүн</b>				<b>243.9</b>			<b>176.7</b>	
1	2018 он	18-р сургууль	Сантехникийн засвар			3.9		98.1
2		Жигүүр цогцолбор	Ангийн засвар			4.9		
3		14-р сургууль	Дотуур байрны засвар			31.2		
4		14-р сургууль А байр	Гадна засвар, ААН-ийн хандив				32.0	
5		Од цогцолбор сургууль	Ариун цэврийн өрөөний засвар, Эцэг эхийн хандиваар				19.8	
6		Од цогцолбор сургууль	Ахлах сургууль ариун цэврийн өрөөний засвар, Эцэг эхийн хандив				6.2	
<b>Дүн</b>						<b>40.0</b>	<b>58.8</b>	
1	2019 он	6-р сургууль	Сантехник, цахилгаан, вакум цонхны засвар, Өвсний үндэс хөтөлбөр				221.9	254.8
2		11-р сургууль	Ариун цэврийн өрөөний засвар, "Хөгжлийн төлөө хамтдаа төсөл хөтөлбөр			20.0		
3		11- сургууль	Дулааны шугамын холболтын засвар			13.0		
<b>Дүн</b>						<b>33.0</b>	<b>221.9</b>	
<b>Нийт дүн</b>				<b>330.9</b>	<b>4.0</b>	<b>129.0</b>	<b>481.2</b>	<b>945.1</b>

## ЕБС-иудад ирсэн хөрөнгийн нэгдсэн дүн

Хөрөнгийн нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он
Тоног төхөөрөмж	290.5	269.9	75.7	98.6
Тавилга эд хогшил	82.7	134.0	113.2	143.7
Сургалтын хэрэглэгдэхүүн	80.8	88.9	70.1	234.8
<b>Дүн</b>	<b>454.0</b>	<b>492.8</b>	<b>259.0</b>	<b>477.1</b>





Төрийн өмчийн сургуулийн нэг суралцагчид ногдох зардал

№	Сургуулийн нэрс	2016 он			2017 он			2018 он			2019 он			4 жилийн дунджаар
		Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	
1	1-р сургууль	865.6	827	1.0	1,046.8	832	1.3	895.9	826	1.1	1,063.4	852	1.2	1.1
2	2-р сургууль	1,436.9	1238	1.2	1,548.2	1197	1.3	1,637.4	1186	1.4	1,747.4	1281	1.4	1.3
3	4-р сургууль	1,108.5	1020	1.1	1,213.1	1016	1.2	1,187.0	1011	1.2	1,390.4	1047	1.3	1.2
4	6-р сургууль	465.6	282	1.6	493.2	294	1.7	505.2	312	1.6	591.0	327	1.8	1.7
5	8-р сургууль	658.5	401	1.6	698.6	393	1.8	702.0	399	1.7	741.5	393	1.9	1.8
6	9-р сургууль	1,191.9	1457	0.8	1,376.3	1580	0.9	1,350.7	1682	0.8	1,617.4	1883	0.8	0.8
7	11-р сургууль	536.0	268	2.0	547.8	250	2.2	570.3	266	2.1	607.2	274	2.2	2.1
8	14-р сургууль	774.2	431	1.8	801.8	418	1.9	833.3	413	2.0	848.4	406	2.1	1.9
9	15-р сургууль	1,311.4	1878	0.7	1,560.2	1919	0.8	1,395.9	1955	0.7	1,668.4	2085	0.8	0.8
10	18-р сургууль	1,144.6	1088	1.0	1,197.9	1060	1.1	1,090.3	1040	1.0	1,302.2	1123	1.2	1.1
11	Жигүүр цогцолбор	1,222.9	1396	0.9	1,288.4	1424	0.9	1,262.0	1484	0.9	1,465.0	1577	0.9	0.9
12	Од цогцолбор	2,048.8	2865	0.7	2,296.0	2923	0.8	2,112.0	3022	0.7	2,623.8	3286	0.8	0.7
13	Оюуны ирээдүй цогцолбор	3,005.4	3887	0.8	3,342.2	3921	0.8	3,284.6	4119	0.8	3,810.7	4534	0.8	0.8
14	Энэрэл цогцолбор	575.9	234	2.5	609.1	233	2.6	598.9	234	2.6	713.7	225	3.2	2.7
15	30-р сургууль	147.8	116	1.3	143.5	144	1.0	137.7	164	0.8	159.1	186	0.8	1.0
16	НТБ төв	295.8	260	1.1	281.1	207	1.6	253.4	195	1.3	311.0	152	2.0	1.5
17	ТИС лицей	33.4	86	0.4	35.6	122	0.3	36.8	105	0.4	71.2	131	0.5	0.3
18	ХААИС лицей	52.8	49	1.1	51.7	55	0.1	32.1	50	0.6	32.1	56	0.6	0.8
<b>Дүн</b>		<b>16,842.9</b>	<b>17,783</b>	<b>1.0</b>	<b>18,531.4</b>	<b>17,988</b>	<b>1.0</b>	<b>17,885.7</b>	<b>18,463</b>	<b>1.0</b>	<b>20,763.9</b>	<b>19,818</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>

Төрийн өмчийн бус сургуулийн нэг суралцагчид ногдох зардал

№	Сургуулийн нэрс	2016 он			2017 он			2018 он			2019 он			4 жилийн дунджаар
		Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох	
1	19-р ахлах сургууль	140.3	359	0.4	145.6	426	0.3	145.6	493	0.3	211.8	453	0.4	0.4
2	Дархан Емпати 21-р сургууль	118.3	362	0.3	132.4	367	0.4	132.4	393	0.3	178.5	417	0.4	0.4
3	24-р ахлах сургууль	86.8	229	0.4	94.7	218	0.4	113.6	156	0.7	94.7	123	0.7	0.6
4	29-р ахлах сургууль	18.0	31	0.6		35	0	20.2	34	0.6	15.6	56	0.3	0.4
5	22-р ахлах сургууль	34.3	98	0.4	36.9	123	0.3	36.9	121	0.3	50.6	105	0.5	0.3
6	Монгол Оюу ахлах сургууль	108.1	227	0.5	111.6	280	0.4	-	309	0	133.4	395	0.3	0.3
7	Союз ахлах сургууль	39.1	101	0.4	42.9	110	0.4	31.5	127	0.3	54.3	159	0.3	0.3
8	Цайхун ахлах сургууль	79.2	174	0.5	86.5	165	0.5	86.4	188	0.5	81.6	302	0.3	0.4
9	Шинэ алхам сургууль								101	0	41.9	246	0.2	0.2
<b>Дүн</b>		<b>624.3</b>	<b>1,581</b>	<b>0.4</b>	<b>650.5</b>	<b>1,724</b>	<b>0.4</b>	<b>566.4</b>	<b>1,821</b>	<b>0.3</b>	<b>862.7</b>	<b>2,256</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>